# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 12 (489)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Боловсролын салбарын мастер төлөвлөгөөний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2007 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот 2007 оны гуравдугаар сарын 25 №12 (489)


## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 168. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 37 | 289 |
| 169. | Австрали Улсын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 41 | 294 |
| 170. | Чэн Линхайнг "Найрамдал" медалиар шагнах тухай | Дугаар 42 | 294 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 171. | Боловсролын салбарын мастер төлөвлөгөөний тухай /үргэлжлэл/ | Дугаар 192 | 295 |


## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2007 оны 02 дугаар сарын 15-ны өдөр** **Дугаар 37** **Улаанбаатар хот**

**Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай**

Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, худалдаа, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, дулаан, эрчим хүч, уул уурхай, тээвэр, онцгой байдал, банк, холбоо, хэвлэл мэдээлэл, улсын бүртгэлийн газар, ус, цаг уур, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Жамъянгийн Батсуурь - Хүн судлалын үндэсний төвийн захирал, доктор, профессор

2. Жамсрангийн Баянцагаан - Монголын уул, дугуй, аяллын клубийн дасгалжуулагч

3. Гунгаагийн Будрагчаа - Нийслэлийн Байгаль хамгаалах газрын дарга

4. Нямын Бэгз - Ой, усны хайгуул судалгааны төвийн ерөнхий нягтлан бодогч

5. Содномын Гаахүү - Ховд аймгийн Жаргалант сум дахь "Түгээмэл амаржуулах хийд" -ийн лам

6. Пүүдэрийн Даваа - Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхий нягтлан бодогч

7. Дашнямын Дарьсүрэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга

8. Санжмятавын Дэлэг - Нийслэл дэх Монгол- Германы хамтарсан хүнсний үйлдвэрлэлийн "ВС- Монгол" ХХК-ийн захирал

9. Дагвын Дэмбэрэлдаш - Нийслэлийн Баянгол дүүргийн ИТХТ-ийн дарга

10. Должинсүрэнгийн Насанбат - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын иргэн, ахмад багш

11. Энэбишийн Сумъяа - Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт

12. Будхүүгийн Хуушаан - Төв аймгийн Жаргалант сумын дунд сургуулийн зөвлөх багш

13. Сумбаагийн Цэгмэд - Гандантэгчинлэн хийдийн оточ маарамба

14. Самбуугийн Цэрэндорж - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Наранбулаг трейд" ХХК-ийн ерөнхий захирал

**ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

Лхамсүрэнгийн Дамдинсүрэн - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны өндөр настан, ахмад холбоочин

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Жаргалын Адъяа - Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум дахь "Шаргал тариа" ХХК-ийн агрономич

2. Доржийн Амгалан - Хөвсгөл аймгийн "Жаргалан" ХХК-ийн захирал

3. Данзангийн Бааст - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Засаг даргын Тамгын газрын дарга

4. Дамдингомбын Баатархуяг - Хэнтий аймгийн ИТХ-ын ажилтан

5. Гонгорын Бадамсүрэн - Булган аймгийн Дашинчилэн сумын Засаг дарга

6. Сүхбаатарын Бадрал - СУИС-ийн харьяа Дүрслэх урлагийн дээд сургуулийн багш

7. Сэджавын Балжинням - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын малчин

8. Даваагийн Басандорж - ШУТИС-ийн багш

9. Бэх-Очирын Батбаасан - Нийслэлийн худалдаа үйлчилгээний "Космо" ХХК-ийн захирал

10. Батжаргалын Батбаяр - УИХ-ын гишүүн

11. Тулгаагийн Бат-Очир - "Монголын Саран ээж нийгэмлэг" ТББ-ын менежер

12. Ванчингийн Батсүх - Сүхбаатар аймгийн Онгон сумын дунд сургуулийн багш, нийгмийн ажилтан

13. Доржпүрэвийн Батхуяг - Хөвсгөл аймгийн Тариалан сумын "Алтан дуулга" ХК-ийн ТУЗ-ийн дарга, "Тэс трейд" ХХК-ийн захирал

14. Доржийн Батчулуун - Орхон аймгийн Жаргалант сумын малчин

15. Дуламжавын Баянжаргал - Монголбанкны Хөвсгөл аймаг дахь салбарын захирал

16. Цэгмидийн Баярмагнай - Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн эрхлэгч, их эмч

17. Гүнчингийн Бурмаа - ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

18. Дондовын Буян - "Монгол шуудан" ХХК-ийн захиргаа, удирдлагын газрын дарга

19. Нямсамбуугийн Буянбадрах - ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологи, дизайны сургуулийн ахлах багш

20. Гомбосүрэнгийн Бямбасүрэн - Өвөрхангай аймгийн Хархорин сумын нийгмийн даатгалын тасгийн дарга

21. Чойжилжавын Ванган - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн менежер

22. Чойжинжавын Ваша - Ховд их сургуулийн хөгжмийн багш

23. Айвын Галимхан - Баян-Өлгий аймгийн Нефть хангамжийн газрын дарга

24. Булданаагийн Ганболд - Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Цэгээн хуст" ХХК-ийн захирал

25. Лууяуугийн Ганболд - Сэлэнгэ аймгийн "Ургацын ундраа" ХХК-ийн ерөнхий захирал

26. Нямдаваагийн Гантөмөр - Удирдлагын академийн санхүү, аж ахуйн албаны дарга

27. Лувсанчултэмийн Даваасамбуу - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Ханбүргэдэй" ХХК-ийн дэд захирал

28. Лхагвасүрэнгийн Дамба - УБТЗ-ын хангамжийн албаны инженер

29. Намнангийн Дашням - Дорнод аймгийн Аудитын газрын ерөнхий аудиторч

30. Пэрэнлэйн Долгорсүрэнхуяг - Хэнтий аймгийн Галшар сумын "Буянт-Оргил булаг" хоршооны малчин

31. Халтуузын Дорж - Завхан аймгийн Алдархаан сумын өндөр настан, Ахмадын хорооны дарга

32. Дамдинхүүгийн Дэмбэрэл - Говь-Алтай аймгийн Тонхил сумын Бүс-Уул багийн малчин

33. Жамъяны Дэндэв - Баянхонгор аймгийн Богд сумын малчин

34. Цэгмидийн Ёндонжамц - Нийслэлийн Налайх дүүргийн 2 дугаар хорооны өндөр настан, ахмад холбоочин

35. Бадамын Жаахүү - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын "Жаргал баг" ХХК-ийн захирал

36. Унасбекийн Кабил - Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын эмч

37. Рустемын Кунишай - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 4 дүгээр ахлах сургуулийн уран зохиолын багш

38. Нямын Лувсангомбо - "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн ашиглалтын албаны дарга

39. Дэмбэрэлийн Лхагва - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын худалдааны ахмад ажилтан

40. Шинжээгийн Лхагважав - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны иргэн, өндөр настан

41. Өндөрийн Лхагвасүрэн - Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөцийн объект 03 дугаар салбарын дарга, шадар ахмад

42. Жавын Лхамжав - Нийслэлийн Баянгол дүүргийн 3 дугаар хорооны засаг дарга

43. Пүрэвжавын Мөнхтөмөр - "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн монтёр-жолооч

44. Балдангийн Мядагсүрэн - Булган аймгийн Булган сумын "Булган-Ачуут" мал эмнэлгийн лабораторийн шинжлэгч эмч

45. Доржийн Нарангэрэл - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр сургуулийн математикийн багш

46. Цэдэнхүүгийн Наранцогт - Төв аймгийн Эрдэнэсант сумын малчин

47. Жамцын Норолхоо - Төв аймаг дахь "Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн борлуулалтын техникч

48. Жамганы Нямсүрэн - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны иргэн , өндөр настан

49. Загдын Оюунханд - Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Баянзүрх" эмнэлгийн зөвлөх эмч

50. Чойнжингийн Оюунчимэг - Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн тасгийн их эмч

51. Гэндэнгийн Пунцаг-Осор - Төв аймгийн Цээл сумын ахмад тариаланч

52. Аюушийн Пүрэв - Архангай аймгийн Батцэнгэл сумын багийн Засаг дарга

53. Пунцагийн Сандагсүрэн - Ховд аймгийн Манхан сумын Ахмадын хорооны дарга

54. Бадарчийн Содномпилжээ - Хөвсгөл аймгийн төр захиргааны ахмад ажилтан

55. Даваадоржийн Соёлзул - Улсын клиникийн нэгдсэн II эмнэлгийн поликлиникийн эрхлэгч

56. Нямсүрэнгийн Соёлмаа - Нийслэл дэх "Соёлмаа" оёдлын салоны эзэн

57. Лхамсүрэнгийн Сугар - Улсын клиникийн нэгдсэн II эмнэлгийн халдвар судлагч их эмч

58. Цэрэвийн Сүрэнжав - Увс аймгийн 11 жилийн 5 дугаар сургуулийн бага ангийн багш

59. Цагаанхүүгийн Сүхээ - Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын их эмч

60. Бандийн Сэлэнгэ - Булган аймгийн Төв номын сангийн хүүхдийн номын санч

61. Сандагийн Сэндум - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны өндөр настан

62. Жунайн Сэрээтэр - Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн уламжлалт эмчилгээний их эмч

63. Долгорын Төмөрбаатар - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтсийн дарга

64. Жамсрангийн Үхэртар - Сангийн яамны Нягтлан бодох бүртгэл, хяналтын газрын дарга

65. Раднаагийн Хайдав - "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн дэд захирал

66. Чойжингийн Хандмаа - Завхан аймгийн Баянтэс сумын дунд сургуулийн бага ангийн багш

67. Раднаабазарын Хатанбаатар - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2 дугаар хорооны иргэн, ахмад жүжигчин

68. Бямбын Хорлоо - Нийслэл дэх санхүү, бүртгэлийн "Их наяд-Аудит" ХХК-ийн захирал

69. Цэгмидийн Цогхүү - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ИТХ-ын ажлын албаны ажилтан

70. Халтарын Цэвээндорж - Дорноговь аймгийн Ахмадын хорооны ажилтан

71. Лувсандоржийн Цэдэнсодном - Говь-сүмбэр аймгийн Биеийн тамир спортын хорооны дарга

72. Сүрэнгийн Цэнд - Баянхонгор аймгийн Өлзийт сумын Засаг дарга

73. Очирын Цэнд-Аюуш - Хөвсгөл аймгийн малчин

74. Даваагийн Чадраабал - Монголын уул, дугуй, аяллын клубийн дасгалжуулагч

75. Бадамдоржийн Чинбат - МУИС-ийн Газар зүй, геологийн факультетийн тэнхмийн багш

76. Мишигдоржийн Чимгээ - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч

77. Лундэгийн Чогсом - Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын Увс аймаг дахь салбарын нягтлан бодогч

78. Доригийн Чулуунжав - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй цогцолбор" 2 дугаар сургуулийн хими биологийн багш

79. Чойсүрэнгийн Шоовдор - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургуулийн нийгмийн ажилтан

80. Чулуунбатын Шуушингаа - Нийслэлийн зураг төсөл, барилга угсралтын "Хар дизайн" ХХК-ийн зураг төслийн инженер

81. Бүрэнтөгсийн Энхтүвшин - Нийслэлийн барилгын "Сэнх" ХХК-ийн захирал

82. Данаасүрэнгийн Энхцэцэг - Монголын хүүхдийн ордны дэд захирал

83. Шоовдорын Эрдэнэбат - Говь-Алтай аймгийн Засаг даргын орлогч

84. Гомбын Эрдэнэбаяр - Монголбанкны хуулийн хэлтсийн захирал

85. Чойжамцын Эрдэнэцэцэг - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн газар зүйн багш

86. Батын Эрдэнэчулуун - Нийслэлийн эрүүл мэндийн "ЭМЖЖ" шүд, чих, хамар хоолойн хувийн эмнэлгийн зөвлөх эмч

87. Цогтын Эрдэнэчулуун - Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий редактор

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Доожийн Бадамсүрэн - Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар багийн өндөр настан

2. Тойжамцын Батболд - ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа

3. Пэлжээгийн Баттогтох - Онцгой байдлын ерөнхий газрын Захиргаа хяналт шинжилгээний газрын дарга, комиссар

4. Цэрэнцэвээний Энхсайхан - УБТЗ дахь цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа

5. Бавуугийн Эрдэнэбаяр - Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Аврах тусгай ангийн захирагч, дэд ахмад

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Дамчаагийн Алтай - Ховд аймгийн Үенч сумын багийн дарга

2. Доржноровын Алтанчимэг - Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даатгалын улсын байцаагч

3. Гүрзийн Амгалан - Монголбанкны Хяналт шалгалтын газрын хянан шалгагч

4. Тангадын Баатарсүрэн - Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх газрын бага эмч

5. Чойжиннямын Батжаргал - Геологийн төв лабораторийн шинжилгээний инженер

6. Жамъяншаравын Батнов - Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны "Хэвлэлийн төв"-ийн захирал

7. Гапсанжамцын Бат-Эрдэнэ - Геологийн төв лабораторийн дэд захирал

8. Нацагийн Баярдалай - Сэлэнгэ аймгийн "Номунхан" ХХК-ийн трактор-комбайнч

9. Гэндэндамбын Баярсайхан - "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн тохирүулгын албаны дарга

10. Загдсүрэнгийн Болдсайхан - Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны удирдах зөвлөлийн гишүүн

11. Уртнасангийн Болормаа - Төв аймгийн Батсүмбэр сумын дунд сургуулийн физик-математикийн багш

12. Банзрагчийн Гал-Эрдэнэ - "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн жолооч

13. Дамбийн Гандолгор - Нийслэлийн Баянгол дүүргийн 11 жилийн 47 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

14. Лханаажавын Ганцогт - Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Цэгээн хуст" ХХК-ийн трактор комбайнч

15. Зундуйн Гарамханд - УБТЗ-ын хангамжийн албаны хяналтын нягтлан бодогч

16. Баатархүүгийн Гэрэлтуяа - Нийслэл дэх "Улаанбаатар буян" ХХК-ийн гүйцэтгэх захирал

17. Сугарын Даваадорж - МҮОНРТ-ийн радиогийн найруулагч

18. Пагмын Давгасүрэн - "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн борлуулалтын байцаагч

19. Вандансодовын Дамбийжанцан - УБТЗ-ын хангамжийн албаны механик инженер

20. Пагмын Данаасүрэн - "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн слесарь

21. Шавирайчийн Дариймаа - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын холбооны гишүүн, гуталчин

22. Жигмэдийн Дашдаваа - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум дахь НААҮ-ний "Шадар туслагч "ХХК-ийн дарга

23. Дунгармаагийн Должинжав - Хөвсгөл аймгийн "Ингол-Золоот" ХХК-ийн ахлах тогооч

24. Самдангийн Доржготов - Хэнтий аймгийн Галшар сумын "Оч" багийн малчин

25. Туваaны Дуламсүрэн - Булган аймгийн номын сан, музей, газар хөдлөлийн станцын ерөнхий нягтлан бодогч

26. Чадраабалын Зоригт - Нийслэлийн Налайх дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн

27. Дамирангийн Ичинноров - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын "Нарлаг Шарын гол" Хоршооны эзэн

28. Гомбын Лхамсүрэн - Говь-Алтай аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн ерөнхий инженер

29. Гомбын Маруся - Нийслэлийн Баянгол дүүргийн "Оюуны ундраа" цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан

30. Гэндэнгийн Мунасүх - Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн нярав

31. Цэрэнхандын Мэрэгшир - УБТЗ-ын хангамжийн албаны ерөнхий нягтлан бодогч

32. Улам-Оргихын Нарандэлгэр - Зоос банкны Төв аймаг дахь 109 дүгээр салбарын захирал

33. Түгжийн Наранцэцэг - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны Засаг дарга

34. Очирын Нармандах - "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн Чингэлтэй салбарын монтёр

35. Доржгочоогийн Норолхоосүрэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хорооны Засаг дарга

36. Дугаржамцын Нямдорж - Дархан-Уул аймгийн "Дарханы дулааны цахилгаан станц" ХК-ийн цехийн засварчин

37. Даваасүрэнгийн Одонтуяа - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн зөвлөх эмч

38. Ишваанжилын Оюунбилэг - Архангай аймгийн Жаргалант сумын цаг уурын харуулын ажиглагч

39. Самбуугийн Оюунгэрэл - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын архив, нууцын эрхлэгч

40. Батдэлгэрийн Оюунчимэг - Булган аймгийн "ГМЭ" хувийн мал эмнэлгийн эрхлэгч, их эмч

41. Ухнын Пагмасүрэн - Сүхбаатар аймгийн Халзан сумын ЗДТГ-ын татварын байцаагч

42. Нэргүйн Пүрэвсэндэн - Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Цэгээн хуст" ХХК-ийн трактор комбайнч

43. Дамдингийн Раднаахаанд - Монгол-банкны Хөвсгөл аймаг дахь салбарын нягтлан бодогч

44. Оронбайн Садель - Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн дарга

45. Цэрэн-Очирын Сайнноров - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 6 дугаар цэцэрлэгийн тогооч

46. Пүрэвээгийн Сашка - Нийслэлийн Налайх дүүргийн 5 дугаар хорооны нийгмийн ажилтан

47. Батдуламын Сувд-Эрдэнэ - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын архив, мэдээллийн сангийн хэлтсийн дарга

48. Мягмарын Сэлэнгэ - Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын ахлах мэргэжилтэн

49. Тирнекейн Тамара - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 4 дүгээр ахлах сургуулийн түүх газар зүйн багш

50. Аюушын Төмөрбаатар - Сэлэнгэ аймгийн Хушаат сумын "Халаалтын төв" ХХК-ийн механик

51. Нинжбадгарын Тунгалаг - Төв аймгийн Архуст сумын дунд сургуулийн захирал

52. Норовсамбуугийн Хишигт - ШУА-ийн түүхийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч

53. Дашзэвэгийн Хулан - Удирдлагын академийн англи хэлний багш

54. Чалхаагийн Хүрэлбаатар - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын санхүү, аж ахуйн хэлтсийн дарга

55. Чулууны Цагаан - МҮОНРТ-ийн Стратеги, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

56. Сүхбатын Цогт - "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн засварын слесарь

57. Содномын Цолмон - МҮОНРТ-ийн зураглаач

58. Аюурзанын Цэнд-Аюуш - Орхон аймгийн "Эрдэнэт прогресс" ХХК-ийн нярав

59. Цаалайжавын Цэенпил - Монголын Улаан загалмай нийгэмлэгийн нарийн бичгийн дарга

60. Дашийн Цэрэн - Нийслэлийн Налайх дүүргийн 1 дүгээр хорооны Ахмадын зөвлөлийн дарга

61. Гомбодоржийн Цэцгээ - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын Бүртгэлийн хэлтсийн дарга

62. Гомбосүрэнгийн Цэцэгмаа - МҮОНРТ-ийн ахлах техникч

63. Дашийн Чулуунбаатар - Нийслэлийн уул уурхай, эрчим хүчний "Баялаг-Орд" ХХК-ийн ерөнхий захирал

64. Самбуугийн Шагдарсүрэн - Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн ус судлалын инженер

65. Сандагсүрэнгийн Энхтүвшин - Нийслэлийн авто тээврийн "Тав" ХК-ийн жолооч

66. Раднаагийн Эрдэнэчимэг - Нийслэлийн худалдаа үйлчилгээний "Макс импэкс" ХХК-ийн харьяа Берлин төвийн тогооч

67. Лувсанцэндийн Янжинсүрэн - "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК-ийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Манлайн Баатар - Дархан-Уул аймгийн Онцгой байдлын хэлтсийн гал унтраах 55 дугаар ангийн захирагч, шадар ахмад

2. Агваан-Осорын Будханд - УМБГ-ын Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн хошууч

3. Дашийн Ганхуяг - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

4. Дамдингийн Нарантуяа - Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын хэлтсийн гамшгаас урьдчилан сэргийлэх хяналтын улсын байцаагч, шадар ахмад

5. Жоошийн Оргодол - Нийслэлийн Хан-Уул дүүргийн гал унтраах 30 дугаар ангийн захирагч

6. Банзрагчийн Пүрэвсүрэн - Дорноговь аймгийн Онцгой байдлын хэлтсийн гамшгаас урьдчилан сэргийлэх хяналтын улсын байцаагч, тэргүүн ахмад

7. Намсрайн Пүрэвсүх - Улсын мөрдөн байцаах газрын Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн хошууч

8. Батмөнхийн Ууганбаяр - Онцгой байдлын ерөнхий газрын хэлтсийн дарга, дэд ахмад

**"ШУДАРГА ЖУРАМ" МЕДАЛИАР:**

ШүрэнцэцэгийнЭрдэнэчулуун - Сэлэнгэ аймаг "Бороо Гоулд" ХХК-ийн экскаваторын оператор

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2007 оны 03 дугаар сарын 07-ны өдөр** **Дугаар 41** **Улаанбаатар хот**

**Австрали Улсын зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай**

Монгол Улс, Австрали Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсыг гадаад оронд сурталчлан таниулах болон монгол судлалд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Австралийн Үндэсний их сургуулийн профессор, монголч эрдэмтэн Игорь Де Рахевилцыг "Алтан гадас" одонгоор, Австрали Улсад суугаа Монгол Улсын Өргөмжит консул Петер Слоуныг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2007 оны 03 дугаар сарын 09-ний өдөр** **Дугаар 42** **Улаанбаатар хот**

**Чэн Линхайнг "Найрамдал" медалиар шагнах тухай**

Монгол Улс, БНХАУ-ын батлан хамгаалах салбар дахь харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе, ахлах хурандаа Чэн Линхайнг "Найрамдал" медалиар шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 08 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 192 | Улаанбаатар хот

**Боловсролын салбарын мастер төлөвлөгөөний тухай**

### МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫГ 2006-2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ*

| | | |
|---|---|---|
| 2.9. Сургуулийн барилгын чанар, дэд бүтэц, цэвэр ус, дулаан, цахилгаан хангамжийг найдвартай болгох, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах | 2.9.1. Төлөвлөгөөний дагуу сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгыг засварлах<br>2.9.2. Сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгын стандартыг шинээр боловсруулж, мөрдөх<br>2.9.3. Дотуур байрны орчны стандартыг боловсруулж, хэрэгжүүлэх<br>2.9.4. Дотуур байрны тавилга, зөөлөн эдлэл, гал тогооны хэрэгсэл, бусад хэрэглэгдэхүүний нийлүүлэлтийг зохион байгуулах<br>2.9.5. Барилгын халаалтын чанартай, үр ашигтай технологийг нэвтрүүлэх, цахилгаан хангамжийг найдвартай болгох<br>2.9.6. Мэргэжлийн байгууллагатай хамтран ундны цэвэр усны нөхцөл байдалд үнэлгээ өгч, бүх сургууль, дотуур байранд гар угаах, чанарын шаардлага хангасан үнэгүй ус уух боломжийг бүрдүүлэх<br>2.9.7. Бүх дотуур байранд халуун усанд орох боломжийг бүрдүүлэн хүрэлцээ, чанарыг сайжруулах<br>2.9.8. Сургууль доторхи болон гадаах бие засах газрын стандартыг боловсруулан хүрэлцээ, хангамж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах<br>2.9.9. Тоног төхөөрөмж, ариутгал, цэвэрлэгээнд тавигдах жишиг шаардлага боловсруулж мөрдөх<br>2.9.10. Сургуулиудын орц, шат, бие засах газар зэргийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үйлчлэх боломжтой болгох | • Чанарын стандартын шаардлага хангасан хичээлийн байрны тоо нэмэгдэнэ.<br>• Бүх сургууль хоёроос илүүгүй ээлжээр хичээллэдэг болсон байна.<br>• Сургууль дээр хичээллэх тохь тухтай орчин бүрдсэн байна.<br>• Хичээлийн байрны суудлын тоотой холбоотой бэрхшээл үүсгэхгүйгээр сургуулийн бүтцийн өөрчлөлт хийгдсэн байна.<br>• Барилгын засварыг захиалах, гүйцэтгэх, хяналт тавих, хүлээн авах ажлын менежмент сайжирна.<br>• Хичээлийн болон дотуур байрны барилгын нөхцөл сайжирч, суралцагчдын тохь тухтай, эрүүл орчинд суралцах, амьдрах тэгш боломж нэмэгдсэн байна.<br>• Барилга ашиглалт тохь тухтай, найдвартай, үр ашигтай болсон байна.<br>• Сургууль ба дотуур байрны усан хангамж, ариун цэврийн өрөөний стандарт боловсрогдож, стандартад нийцсэн ундны ус, бие засах газар, халуун ус, ариун цэврийн өрөөгөөр сургууль бүр хангагдана |
| 2.10. Бага, дунд боловсролын стандарт, кирикюлимийн хэрэгжилт, түүнийг дэмжих орчин, үйл ажиллагаа үнэлэх | 2.10.1. Стандартын хэрэгжилтийг хөндлөнгөөс тогтоох бүтэц, арга хэлбэрийг шинэчлэх<br>2.10.2. Сурагчийн сурлагын амжилтын үнэлгээг суралцах болон багшлах үйл явцыг дэмжих хөшүүрэг болгон өөрчлөх<br>2.10.3. Багш, удирдах ажилтны ажил, сургууль, боловсролын байгууллагын үйл ажиллагаа үнэлэх арга хэлбэрийг боловсронгуй болгох<br>2.10.4. Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээнд цахим программууд ашиглаж, үнэлгээний үр дүн, мэдээллийн чанарыг сайжруулан хэрэглээг нэмэгдүүлэх<br>2.10.5. Англи хэлний суурь болон бүрэн дунд боловсролын стандарт тогтоох шалгалтыг улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар зохион байгуулж үр дүнд нь дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргана. | • Сурлагын амжилтын үнэлгээ нь суралцах, багшлах үйл явцыг дэмжих хөшүүрэг болон өөрчлөгдөнө.<br>• 2008 он гэхэд суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тогтолцоо тогтворжино.<br>• 2010 он гэхэд стандартын хэрэгжилтийн үнэлгээний тогтолцоо тогтворжино.<br>• Боловсролын стандартын хэрэгжилтийг үнэлэх байгууллагын болон хүний нөөцийн чадавхи нэмэгдэнэ.<br>• Суурь боловсрол амжилттай эзэмшин төгсөгчдийн хувийг 99.5 хувьд хүргэнэ.<br>• Ахлах ангийг амжилттай төгсөгчдийн хувийг 99.9 хувьд хүргэнэ. |

** Засгийн газрын 2006 оны 192 дугаар тогтоолын хавсралтын үргэлжлэл. Түрүүч нь "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 11 дүгээрт нийтлэгдсэн.*

| | | |
|---|---|---|
| 2.11. Цогцолбор, бүсийн төв сургуулиудын хөгжлийг дэмжих | 2.11.1. Цогцолбор сургуулийн давуу тал, ололт амжилтыг баяжуулан баталгаажуулах, гарч буй бэрхшээлийг арилгах, сургалтын таатай орчныг бүрдүүлэх, сургалтын техник, технологийн шинэчлэлийг тасралтгүй хийж байх талаар чиг зорилготой цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх<br>2.11.2. Цогцолбор болон бүсийн төв сургуулиудыг зайн сургалтын үндэсний системд холбох, шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх<br>2.11.3. Мэдээлэл холбооны технологийн сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх төвүүдийг бий болгох<br>2.11.4. Цогцолбор ба бүсийн төв сургуулиудад мэргэжлийн сургалт явуулах орчин нөхцөл бүрдүүлэх | • Орон нутгийн БСГ багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээ явуулах түшиц сургуулиудтай болно.<br>• Мэргэжлийн сургалттай ЕБС-иуд бий болно.<br>• Мэдээлэл, холбооны технологийг сургалтад хэрэглэх загвар сургуулиуд бий болж, бусад сургуулиудад туслалцаа, дэмжлэг үзүүлдэг болно.<br>• Цогцолбор ба бүсийн сургуулиудын сүлжээ үүснэ. |
| МЕНЕЖМЕНТ | | |
| Зорилго 3. Сургуулийг дэмжих бодлого, менежментийг боловсронгуй болгож хөгжүүлэх | | |
| 3.1. Удирдах ажилтнуудын ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэх, цалин хөлс, нийгмийн хамгааллыг сайжруулах | 3.1.1. Боловсролын үйл хэргийг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, орон тоог оновчтой болгох, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх<br>3.1.2. Бүх түвшний менежерүүдэд зориулсан сургалтын иж бүрэн модулийг сургалтын оновчтой загвар ашиглан хэрэгжүүлэх<br>3.1.3. Боловсролын захиргааны, мэргэжлийн удирдлага болон хяналт-шинжилгээ, үнэлгээний бүх түвшний менежерүүдийн ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэх<br>3.1.4. Албан тушаалд менежерийн ур чадвар, ёс зүйг үндсэн шалгуур болгож сонгон шалгаруулах | • Зорилтод бүлэг бүрийн ажлын байрны тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлж, хүний нөөцийн удирдлагын чиг үүргийг албажуулсан байна.<br>• Ажлын байранд тавигдсан ур чадварыг хөгжүүлэхтэй холбоотой зорилтот бүлэг бүрт зориулсан сургалтын модулиуд боловсруулж цуврал сургалт зохион байгуулна.<br>• Удирдах ажилтныг сонгох шалгаруулалт шударга, нээлттэй болно. |
| 3.2. Сургуульд суурилсан удирдлагыг хөгжүүлэх | 3.2.1. Сургуулийн өөрийн удирдлагыг хөгжүүлэх<br>3.2.2. Сургуульд ажиллагчдын гүйцэтгэх чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтыг үнэлж сайжруулах<br>3.2.3. Тухайн ажлын байранд сонгон шалгаруулах, томилох, ажиллуулах, ажлыг нь үнэлж дүгнэх арга, хэлбэрийг боловсронгуй болгох<br>3.2.4. "Хүүхдэд ээлтэй сургууль", "Эрүүл мэндийг дэмжигч сургууль", "Ногоон сургууль", "Нээлттэй сургууль"-ийн үзэл санаа, арга зүйг нэвтрүүлэх<br>3.2.5. Сургуулийн захиргааны болон сургалтын албан хэргийн нэр төрлийг оновчтой болгон тэдгээрийн хөтлөлт, мэдээлэл солилцоонд шинэ программ хангамж, технологи нэвтрүүлэх<br>3.2.6. Сургуулийн удирдлагын тайланг тогтмолжуулж, эцэг эх, сурагч, төр, олон нийтээр үнэлүүлж, хариуцлага тооцох арга зүйг боловсронгуй болгох<br>3.2.7. Сургалтын үйл ажиллагаа явуулах дадлагын болон туслах аж ахуй, сургалт үйлдвэрлэлийн нэгжүүдийг оновчтой сонгон зохион байгуулж олсон орлогыг сургуулиа хөгжүүлэхэд хууль эрх зүйн хүрээнд зарцуулахыг дэмжих | • Сургуулийн зөвлөлийн чадавхи дээшилсэн байна.<br>• Сургуулийн санхүүгийн бие даасан байдал нэмэгдсэн байна.<br>• Сургуулиуд хэрэглэгч, сонирхогчдоо нээлттэй байж тэднийг үнэн зөв, шуурхай мэдээллээр хангаж, үйл ажиллагаагаа байнга сайжруулж байх боломж бүрдэнэ.<br>• Сургуулийн сургалтын албан хэргийн хөтлөлт хөнгөн шуурхай болно.<br>• Сургуулийн хөгжлийн олон улсын туршлага, жишиг нэвтэрнэ. |

| | | |
|---|---|---|
| 3.3. Боловсролын эрэлт хэрэгцээний өсөлтийг хангаж оролцогч талуудын сонирхлыг зохицуулах | 3.3.1. Оролцогчдын сонирхол, хэрэгцээг судлах<br>3.3.2. Мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа зохицуулах арга хэлбэр бий болгох<br>3.3.3. ЕБС-д иргэд болон хувийн хэвшлээс хөрөнгө оруулалт хийх санаачилгыг дэмжих<br>3.3.4. Боловсролын салбарын хөгжлийг дэмжсэн хандивлагчид болон иргэний нийгмийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэх | • Аливаа үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд сонирхогч талуудын оролцоог бодитой болгон мэдээллийг ил тод байлгаж, гарсан зөрчил дутагдлыг арилгах арга хэлбэр боловсронгуй болсон байна<br>• Хууль журмын дагуу боловсролыг дэмжих өс зүйтэй нийгмийн оролцоо нэмэгдэнэ. |

| | |
|---|---|
| Дам үр дүн ба шалгуур үзүүлэлт | • Суралцах боломж нь хязгаарлагдсан, эрх нь зөрчигдсөн хүүхдүүд боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжтой болно. |
| | • Хот, хөдөөд бага, дунд боловсролын хүртээмж болон чанарын ялгаа багасна. |
| | • Бага боловсролын хамран сургалтын бохир жин 99.1 хувьд, дунд ангийн хамран сургалтын бохир жин 97.2 хувьд, суурь боловсролын хамран сургалтын бохир жин 98.3 хувьд тус тус хүрнэ. |
| | • Багш бүрийн мэргэжлийн болон арга зүйн хөгжилд бодит ахиц гарч, шинэ стандарт, кирриюлимийг хэрэгжүүлэх боломжтой болно. |
| | • Боловсролын хөгжилд оруулах нийгмийн оролцооны үр өгөөж нэмэгдэж, суралцагчдын чанартай боловсрол эзэмшихэд шаардагдах орчин нөхцөл сайжирна. |
| | • Бага, суурь боловсрол эзэмшигчид нь дараагийн түвшний чанартай боловсрол эзэмших, бие даан ажиллаж, амьдрах тэгш боломж нэмэгдэнэ. |
| | • 2008-2009 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлнэ. |
| | • Гадаад улстай боловсролын баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөлцөх нөхцөл хангагдана. |

4.3. Албан бус, насанд хүрэгчдийн боловсролын дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө (2006 - 2010 он)

| Хэрэгжүүлэх хөтөлбөр | Хөтөлбөрийн бүрэлдэхүүн | Гаралтын үр дүн ба шалгуур үзүүлэлт |
|---|---|---|
| | Хүртээмж | |
| Зорилго 1. Хүн амын сурах, амьдрах хэрэгцээнд тохирсон тасралтгүй боловсролын үйлчилгээ үзүүлэх АББ ба насанд хүрэгчдийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх | | |
| 1.1. Бичиг үсэг үл мэдэгч, шинээр тайлагдсан хүмүүст зориулсан албан бус боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1.1. Хүн амын бичиг үсгийн боловсролын түвшинг тогтоох шалгуур үзүүлэлт боловсруулан бичиг үсгийн нарийвчилсан судалгаа явуулах<br>1.1.2. Бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгч (40-өөс доош насны)-дэд зориулсан бичиг үсгийн анхан шатны болон бичиг үсэг сурсны дараахь сургалтын хөтөлбөр, сургалтын материалын хэлбэр, нэр төрлийг олшруулах, сургалтыг тогтмолжуулж, хамралтыг нэмэгдүүлэх | • Бичиг үсэгт тайлагдсан түвшинг 99.0 хувьд хүргэнэ.<br>• Албан бус боловсрол, гэгээрэл хөгжлийн төвүүдэд хамрагдах бичиг үсэг үл мэдэх эмэгтэйчүүдийн хувь 2005 оны түвшнээс 24.7 хувиар нэмэгдэж 52.7 хувьд, бичиг үсэг үл мэдэх эрэгтэйчүүдийн хувь 22.3 хувиар нэмэгдэж 65.2 хувьд тус тус хүрсэн байна. |
| 1.2. Сургуулийн гадна буй хүүхэд, залуус албан бус боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх | 1.2.1. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтын модуль гарган хэрэглэх<br>1.2.2. Боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдаж буй сургуулийн насны хүүхдийг хувьсах зардалд хамруулан, санхүүгийн асуудлыг шийдэх<br>1.2.3. Дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр суралцагчдад хичээл заах АББ-ын багш нарыг бэлтгэх | • Ерөнхий боловсролын сургуулиас завсардсан суралцагчдын 40 хувийг албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамруулж, боловсрол нөхөн олгодог болсон байна.<br>• Дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн байдлыг баталгаажуулах эрх зүйн орчин бүрдсэн байна.<br>• АББ-ын сургалтад хамрагдах хугацаанд нь сургуулийн насны хүүхдэд хувьсах зардал бүрэн олгодог болсон байна.<br>• Дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр хичээл заах багш бэлтгэгдэнэ |
| 1.3. Насанд хүрэгчдийн сурах, амьдрах хэрэгцээнд тохирсон тасралтгүй боловсролын үйлчилгээний хүрээг өргөжүүлэх | 1.3.1. Насанд хүрэгчдийн боловсролын түвшин, хэрэгцээний нарийвчилсан судалгааг олон улсын аргачлалын дагуу хийх<br>1.3.2. АББ-ын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, суралцагчдын хэрэгцээнд тулгуурласан амьдрах ухаан, өрхийн орлого нэмэгдүүлэх, боловсролын ерөнхий түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэглэх | • Насанд хүрэгчдийн боловсролын түвшин, хэрэгцээний нарийвчилсан судалгаа хийгдэж суурь мэдээлэлтэй болсон байна.<br>• Насанд хүрэгчдийн хэрэгцээнд тохирсон хүртээмжтэй, чанартай АББ-ын тогтвортой үйлчилгээ бий болсон байна. |
| | ЧАНАР | |
| Зорилго 2. АББ-ын бүх түвшинд сургалтын орчин, чанар, нөөцийн чадавхийг дээшлүүлэх | | |
| 2.1. АББ ба насанд хүрэгчдийн боловсролын салбарын сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгож, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг сайжруулах | 2.1.1. Бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтын агуулга, арга зүйг боловсролын шинэ стандарттай уялдуулан өөрчлөх<br>2.1.2. Дүйцсэн сургалтад холимог бүлгийн сургалтын арга зүйг нэвтрүүлэх, онол арга зүйн үндэслэлийг судлан өөрийн онцлогт тохирсон оновчтой хувилбарыг боловсруулах<br>2.1.3. Насанд хүрэгчдийн боловсролын хэрэгцээ, онцлогт тохирсон АББ-ын төрөл бүрийн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүний чанарыг дээшлүүлэх | • Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрүүд, түүнийг хэрэгжүүлэх сургалтын модулиуд боловсруулагдаж гарсан байна.<br>• Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад холимог бүлгийн сургалтын арга зүйг ашигладаг болсон байна.<br>• АББ-ын төрөл бүрийн сургалтын хөтөлбөр, сургалтын материалууд боловсруулагдаж, хэрэглэгдэнэ. |

| | | |
|---|---|---|
| 2.2. АББ-ын үйлчилгээ эрхлэгч байгууллага, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх | 2.2.1. АББ-ын багш нарын боловсон хүчний хүрэлцээ хангамжийг сайжруулах<br>2.2.2. АББ-ын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, ажиллагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлэх | • АББ-ын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, гарын авлага гарч, сургалт тогтмолжсон байна.<br>• АББ-ын байгууллагуудын чадавхи бүх түвшинд сайжирч, ялангуяа хүний нөөц, боловсон хүчний хангамж нэмэгдсэн байна. |
| 2.3. АББ ба насанд хүрэгчдийн боловсролын чанарыг бүх түвшинд сайжруулж, сургалтын орчин, нөөцийг бэхжүүлэх | 2.3.1. АББ-ын Гэгээрлийн төвүүдийн хүчин чадал, нөөцийг нэмэгдүүлж, сургалтын орчинг сайжруулах<br>2.3.2. Албан бус болон нээлттэй хэлбэрээр бага, суурь боловсрол эзэмших сургалтын чанарыг үнэлэх ажлыг албан сургалтын байгууллагатай хамтран хийдэг болох | • Бичиг үсэгт тайлагдсан хүмүүсийн бичиг үсгийн хэрэглээний чадвар өссөн байна.<br>• АББ-ын төрөл бүрийн чиглэлээр хэвлэмэл, дуут, дүрст, CD хэрэглэгдэхүүн гарч Гэгээрлийн төвүүд болон бусад хэрэгцээт газар сургалтад хэрэглэгдсэн байна. |
| МЕНЕЖМЕНТ | | |
| Зорилго 3. АББ-ын салбарын бодлого, стратегийг боловсронгуй болгож, мэдээллийн болон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх | | |
| 3.1. АББ ба насанд хүрэгчдийн боловсролын бодлого, стратегийг шинэчлэн боловсруулах | 3.1.1. АББ-ын салбарын бодлого, стратегийг нийт хүн ам тасралтгүй насан туршдаа суралцах боломжийг хангалттай бүрдүүлж чадахуйцаар тодорхойлох<br>3.1.2. АББ-ын үндэсний болон орон нутгийн байгууллагуудыг бэхжүүлэх, тэдгээрийн байр суурийг тодорхой болгох<br>3.1.3. Ядуу, эмзэг бүлгийнхэн, ажилгүйчүүдэд зохих шатны боловсрол, мэргэжил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн сантай нийцүүлэн эрх зүйн орчинг сайжруулах | • АББ-ын салбарын бодлого, стратеги шинэчлэгдэн тодорхойлогдож амжилттай хэрэгжиж байна. |
| 3.2. Төрөөс албан бус боловсролыг санхүүжүүлэх харилцааг боловсронгуй болгох | 3.2.1. Боловсролын болон төсвийн тухай хуульд санхүүжилтийн механизмыг тодорхой болгон тусгах<br>3.2.2. АББ-д зарцуулагдах санхүүжилтийг нэмэгдүүлж, тусад нь төлөвлөх<br>3.2.3. АББ-д зориулсан санхүүжилтийг үндэсний болон орон нутгийн түвшинд оновчтой хуваарилдаг болгох | • АББ-ын санхүүжилтийн арга хэлбэрийг тогтвортой, тодорхой болгоно.<br>• АББ-д зориулсан санхүүжилт нэмэгдсэн байна.<br>• Үндэсний болон орон нутгийн түвшин дэх санхүүжилтийн хуваарилалт тодорхой болж, тогтворжсон байна. |
| 3.3. АББ-ын удирдлага, төлөвлөлт, мэдээллийг бүх шатанд боловсронгуй болгож, мэдээлэл, хяналт шинжилгээ-үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх | 3.3.1. АББ-д мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх, мэдээллийг цуглуулах, боловсруулах, солилцох, ашиглах тодорхой аргачлал бий болгох.<br>3.3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох | • Удирдлага, мэдээллийн тогтолцоо, түүнд тулгуурласан АББ-ын бодлого, төлөвлөлт, удирдлагын бичил тогтолцоо бий болсон байна. |

| | |
|---|---|
| Дам үр дүн ба шалгуур үзүүлэлт | Бүх нийтээр бага, суурь боловсрол эзэмшиж, хүйсийн тэнцвэрт байдал хангагдана. |
| | Насан туршийн сургалтын орчин бүрдэж, амьдралын чанар дээшилснээр ядуурлыг бууруулна |
| | Нийт хүн ам хэрэгцээт боловсролоо албан сургуулиас гадуур олж эзэмших боломж нэмэгдэнэ.. |
| | АББ ба насанд хүрэгчдийн боловсролын бодлого, эрх зүйн орчин бүрдэж үйл ажиллагаа тогтмолжин үр ашиг дээшилнэ. |
| | Бодит мэдээлэлд тулгуурласан төлөвлөлт хийгдэж, удирдлага сайжирснаар АББ-ын үйлчилгээ хангалттай түвшинд хүрнэ. |

4.4. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө (2006- 2010 он)

| Хэрэгжүүлэх хөтөлбөр | Хөтөлбөрийн бүрэлдэхүүн | Гаралтын үр дүн ба шалгуур үзүүлэлт |
|---|---|---|
| | Хүртээмж | |
| Зорилго 1. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын хамран сургалтыг 56.1 хувиар нэмэгдүүлнэ. | | |
| 1.1. МСТБ-ын сургалтын төрөл, хамрах хүрээг өргөжүүлэх | 1.1.1. МСТБ-ын сургуулийн суудлын тоог нэмэгдүүлэх<br>1.1.2. МСҮТ-дийн дотуур байрны засвар, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах<br>1.1.3. Бүсчилсэн хөгжлийн үндэсний стратеги, орон нутгийн хэрэгцээтэй уялдуулан МСҮТ-ийг шинээр байгуулах<br>1.1.4. Эмзэг бүлгийн суралцагчдын суралцах боломжийг хангах талаар ялгаатай, тэнцүүлэх бодлогыг хэрэгжүүлэх<br>1.1.5. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын эмзэг бүлгийн суралцагчдад сурах бичиг, сургалтын гарын авлагыг номын сангаар дамжуулан үнэ төлбөргүй эзэмшүүлэх<br>1.1.6. Бүрэн дунд боловсролын сургууль төгсөгчдийн элсэлтийн хувийг нэмэгдүүлэх<br>1.1.7. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын хамрагдан сургалтад насанд хүрэгчдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх<br>1.1.8. Суралцагчийн сонголтын дагуу боломж бүрдсэн ерөнхий боловсролын сургуулиудад мэргэжлийн анхан шатны сургалт зохион байгуулах | ▪ Мэргэжлийн анхан, дунд боловсрол олгох сургуулийн 3.800 суудал бүхий хичээлийн байрыг шинээр барина.<br>▪ Суурь боловсрол эзэмшин төгсөгчдөөс МСҮТ-д элсэгчид 2005 онтой харьцуулбал 6.6 хувиар буурч 7.6 хувь болсон байна.<br>▪ Бүрэн дунд боловсролын сургуулийг төгсөгчдөөс МСҮТ-д элсэгчид 6.0 хувиар нэмэгдэж 8.0-аас доошгүй хувьд хүрсэн байна.<br>▪ Мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургуулиуд бий болсон байна.<br>▪ Бүрэн дунд боловсролын сургуульд олгох мэргэжлийн жагсаалт баталгаажсан байна. |
| 1.2. Хувийн МСТБ-ын сургууль байгуулахыг дэмжих | 1.2.1. Хувийн МСҮТ-дийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг төрөөс хариуцах<br>1.2.2. Хувийн болон төрийн МСҮТ -ийн дадлагын баазыг харилцан ашиглах хэлбэр бий болгох<br>1.2.3. Үйлдвэр, аж ахуйн дэргэд МСҮТ байгуулах бодлого, эрх зүйн таатай орчин бий болгох<br>1.2.4. Хувийн МСҮТ-дийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | ▪ МСТБ-ын хувийн сургуулиудад суралцагчдын хувь 2005 онтой харьцуулахад 3.0 хувиар нэмэгдэж 4.4 хувьд хүрсэн байна. |
| | ЧАНАР | |
| Зорилго 2. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын сургалтын чанарыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжилтэй ажиллах хүчний хэрэгцээг хангахуйц нийлүүлэлтийг бий болгох | | |
| 2.1. МСТБ-ын сургалтыг ажиллах хүчний эрэлтэд нийцүүлэх | 2.1.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн тоо, чанар, нийгмийн үр өгөөжийн судалгаа хийх<br>2.1.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн мэдээллийн систем бий болгох<br>2.1.3. Зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн сургалтын агуулга, стандарт боловсруулах<br>2.1.4. МСТБ-ын сургуулийн удирдлага, төлөвлөлт болон сургалтын үйл ажиллагаанд үйлдвэрлэл, үйлчилгээний оролцоог нэмэгдүүлэх<br>2.1.5. Сургалтын модулийн сан байгуулах | ▪ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн мэдээллийн систем бий болсон байна.<br>▪ Түгээмэл мэргэжлүүдийн агуулга, стандарт боловсруулагдаж батлагдсан байна. |

| | | |
|---|---|---|
| 2.2. МСТБ-ын сургалтын материаллаг бааз, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хангамжийг сайжруулах | 2.2.1. Засварлах шаардлагатай төрийн өмчийн МСҮТ-ийн барилгын засварын санхүүжилтийг шийдвэрлэх<br>2.2.2. Төрийн өмчийн МСҮТ-ийн дадлагын газар, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх<br>2.2.3. МСТБ-ын мэргэжлийн сурах бичгийг зохиох, хэвлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх<br>2.2.4. Сурах бичгээр хангахад ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлэх, ЕБС дээр явагдах боломжтой мэргэжлийн анхан шатны сургалтын агуулга, модульчилсан хөтөлбөр боловсруулах<br>2.2.5. Мэргэжлийн анхан шатны боловсрол олгох сургалттай ЕБС-иудыг дадлага, лабораторийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах | • ЕБС-иудад зориулсан мэргэжлийн анхан шатны сургалтын модульчилсан хөтөлбөрүүд бий болно.<br>• Сурах бичгийн бодлого гарч, хэрэгжинэ.<br>• Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын лабораторийн тоног, төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг жил бүр 10.0 хувиар өсгөнө.<br>• 28 дадлагын газар шинэчлэгдэж, сургууль дундын дадлагын төв байгуулагдан 26 сургуульд их засвар хийж, 6 загвар сургуультай болсон байна. |
| 2.3. Багш бэлтгэх, давтан бэлтгэх, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх | 2.3.1. МСТБ-ын багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэний тогтолцоог бий болгох<br>2.3.2. МСТБ-ын багш нарын мэргэжил дээшлүүлэх санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлэх<br>2.3.3. Мастер багш, мэргэжлийн хичээлийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулах<br>2.3.4. Мэргэжлийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх шинэ техник, дэвшилтэт технологийн сургалтын төвийг байгуулах<br>2.3.5. МСТБ-ын онол, дадлагын хичээлийг зэрэг заах чадвартай мэргэжлийн багшийн тоог нэмэгдүүлэх | • Багш бэлтгэх, давтан бэлтгэх тогтолцоо бий болсон байна.<br>• МСҮТ-үүд мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан байна.<br>• МСТБ-ын багш нарын 50.0-иас доошгүй хувийн мэргэжлийг дээшлүүлнэ.<br>• Жил бүр 20 багшийг гадаадад нарийн мэргэжлээр мэргэшүүлэх мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.<br>• Мэргэжлийн багш нарын мэргэжил дээшлүүлэх дэвшилтэт технологийн төв байгуулагдана. |
| МЕНЕЖМЕНТ | | |
| Зорилго 3. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын менежментийг шинэчлэх | | |
| 3.1. МСТБ-ын удирдлага, санхүүжилтийн арга хэлбэрийг боловсронгуй болгох | 3.1.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх бодит зардлын үндсэн дээр санхүүжилтийн норм, нормативыг шинэчлэн мөрдөх<br>3.1.2. МСТБ-ын сургуулийг сургалт, бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх<br>3.1.3. МСТБ-ын үндэсний болон сургуулийн удирдлагын чадавхийг сайжруулах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх<br>3.1.4. МСТБ-ын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн чадавхийг бэхжүүлэх, чанарын хяналтын тогтолцоог бий болгох<br>3.1.5. МСТБ-ын гадаад хөрөнгө оруулалтыг дэмжих таатай орчин бий болгох | • МСТБ-ын санхүүжилтийн норм, норматив шинэчлэгдсэн байна.<br>• МСТБ-ын үндэсний болон сургуулийн чадавхи сайжирсан байна.<br>• Чанарын хяналтын систем бий болсон байна. |

| | | |
|---|---|---|
| 3.2. Нийгмийн түншлэлийн бүтцийг бий болгох | 3.2.1. Ажил олгогчид, үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнесийн мэргэжлийн холбоодын төлөөллийг үндэсний түвшний бодлого, төлөвлөлтөд оролцуулах<br>3.2.2. Нийгмийн түншлэлийн бүтцийг бий болгосноор сургалт, үйлдвэрлэл, үйлчилгээний уялдаа холбоог хангах, төгсөгчдийг ажлын байраар хангах | ▪ Үндэсний болон сургуулийн түвшинд нийгмийн түншлэл бий болсон байна. |

| | |
|---|---|
| Дам үр дүн ба шалгуур үзүүлэлт | МСТБ-ын үйлчилгээ сайжирснаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурал, ажилгүйдэл бууруулахад нөлөөлнө. |
| | Үндэсний мэргэжилтэй ажилчдын чадавхи сайжирснаар үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, эдийн засгийн өсөлт бий болоход дэмжлэг үзүүлнэ. |

4.5. Дээд боловсролын дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө
(2006- 2010 он)

| Хэрэгжүүлэх хөтөлбөр | Хөтөлбөрийн бүрэлдэхүүн | Гарaлтын үр дүн ба шалгуур үзүүлэлт |
|---|---|---|
| Хүртээмж | | |
| Зорилго 1. Дээд боловсролын хамран сургалтын зохицуулалтыг сайжруулах | | |
| 1.1. Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, ХАА-н мэргэжлээр суралцагчдыг дэмжих | 1.1.1. Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, ХАА-н чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын сургалтын орчныг сайжруулахад дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг нэмэгдүүлэх<br>1.1.2. Засгийн газар хоорондын хэлэлцээр, буцалтгүй тусламжийн хүрээнд гадаад оронд суралцагчдын дотор инженер, технологийн мэргэжил эзэмшигчдийн хувийн жинг жил бүр нэмэгдүүлэх<br>1.1.3. Төрийн сургалтын сангаас олгох сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн бодлогоор дамжуулан инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, ХАА-н мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг нэмэгдүүлэх | • Нийт суралцагчдын дотор инженер, технологийн мэргэжлээр суралцагчдын эзлэх хувь 18.8%, байгалийн шинжлэлийн мэргэжлийн чиглэлээр суралцагчдын хувь 3.5%, багшийн мэргэжлээр суралцагчдын хувь 9.9%, ХАА-н мэргэжлээр суралцагчдын хувь 4.5% тус тус болсон байна.<br>• Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, ХАА-н мэргэжлийн чиглэлээр суралцагч нийт оюутны 75% нь СТС-гийн зээлд хамрагдсан байна. |
| 1.2. Их, дээд сургуулиудын үйлчилгээний хүрээг өргөжүүлэх | 1.2.1. Нэлттэй их сургууль байгуулах үүсгэл санаачилгыг дэмжих<br>1.2.2. Гадаадын нэр хүндтэй их сургууль, коллежийн салбарыг байгуулах<br>1.2.3. Мэргэжлийн эчнээ болон алсын зайн сургалтыг өргөжүүлэх<br>1.2.4. Дээд боловсролтой төгсөгчдийн тасралтгүй суралцах боломжийг өргөжүүлэх | ▪ Гадаадын нэр хүндтэй их сургууль, коллежийн салбарууд шинээр байгуулагдаж тэдгээрт суралцагчдын тоо нэмэгдсэн байна.<br>▪ Цахим сургууль байгуулагдсан байна.<br>▪ Нээлттэй их сургуулийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулиуд бий болсон байна. |

| | | |
|---|---|---|
| ЧАНАР | | |
| Зорилго 2. Дээд боловсролын сургалтын чанарын баталгааг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх | | |
| 2.1. Дээд боловсролд ажиллагчдын мэргэжлийн чадавхийг бэхжүүлэх | 2.1.1. Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх<br>2.1.2. Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад эрдэм шинжилгээний боловсон хүчин, залуу эрдэмтдийг бэлтгэх<br>2.1.3. Багш нарын мэргэжил дээшлүүлэх санхүүгийн эх үүсвэрийг өргөжүүлэх<br>2.1.4. Багш нарын мэргэжил дээшлүүлэхэд мэдээлэл харилцааны технологийг өргөн ашиглах, хөрөнгө оруулалт хийх | • Дээд боловсролын багш нарын дотоодод мэргэжил дээшлүүлэх зардлын жилийн өсөлт 8% байна.<br>• Жил бүр 100 багш гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна.<br>• Зайны сургалтын улсын нэгдсэн сүлжээ байгууллагдан багшийн мэргэшлийг дээшлүүлэхэд ашиглагдана. |
| 2.2. Дээд боловсролын байгууллагын ажил, үйлчилгээний стандарт, магадлан итгэмжлэлийг хөгжүүлэх | 2.2.1. Дээд боловсролын сургалтын байгууллагуудын сургалт судалгааны ажил, сургалтын орчны стандартуудыг боловсруулж хэрэгжүүлэх<br>2.2.2. Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд тавих шаардлага, шалгуурыг боловсронгуй болгон мөрдүүлэх<br>2.2.3. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн байгууллагын чиг үүргийг олон улсын жишигт нийцүүлэх<br>2.2.4. Дээд боловсролын байгууллагад ажиллагчдын ажил, үйлчилгээний стандарт, магадлан итгэмжлэлийг бий болгох<br>2.2.5. Их, дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажилд баримтлах ёс зүйн дүрмийг боловсруулж мөрдүүлэх<br>2.2.6. Гадаад оронтой боловсролын баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх | • Дээд боловсролын сургалтын байгууллагын зэрэглэлийг тогтоож нийтэд мэдээлдэг болсон байна.<br>• Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг олон улсын стандартад нийцүүлсэн байна.<br>• Дээд боловсролын байгууллагад ажиллагчдын ажил, үйлчилгээний стандарт бий болсон байна.<br>• Дээд боловсролын сургалтын байгууллагыг үе шаттайгаар аттестатчилдаг болсон байна.<br>• Хувийн их, дээд сургуулийн оюутнуудын нийт суралцагчдад эзлэх хувь 2005 оны түвшнээс 3.8%-иар буурч 27.9% болсон байна. |
| 2.3. Их, дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх | 2.3.1. Их, дээд сургуулийн техник, технологийг дэмжихэд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогын таатай орчин бүрдүүлэх<br>2.3.2. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээний судалгаа, үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх<br>2.3.3. Их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх талаар гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх<br>2.3.4. Их, дээд сургуулиудаас гадаадын их, дээд сургууль, судалгааны байгууллагуудтай эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн хамтарсан судалгаа хийх талаар хоёр болон олон талт гадаад харилцааны таатай орчин бүрдүүлэх | • Дээд боловсролын хөрөнгө оруулалтын зардал жил бүр 8%-иар өссөн байна.<br>• Их, дээд сургуулийн сургалтад дэвшилтэт техник, технологиуд нэвтэрсэн байна.<br>• Их, дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний судалгаа, үйлдвэрлэлийн уялдаа холбоо сайжирсан байна. |

| МЕНЕЖМЕНТ | | |
|---|---|---|
| Зорилго 3. Дээд боловсролын удирдлага, санхүүгийн тогтолцоог оновчтой болгох | | |
| 3.1. Дээд боловсролын удирдлага зохицуулалтыг оновчтой болгох | 3.1.1. Их, дээд сургуулийн удирдах ажилтны удирдлагын ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх тогтолцоог бий болгох<br>3.1.2. Өндөр хөгжилтэй орнуудад оюутан суралцуулах нээлттэй боломжийг өргөжүүлэх, зээлийн эргэн төлөлтийн бодлогыг боловсронгуй болгох<br>3.1.3. Их, дээд сургуульд элсэгчдийн бүтцийг оновчтой болгох<br>3.1.4. Төрийн өмчийн их, дээд сургуулийг нийгмийн салбарын хувьчлалд хамруулах бодлого, стратегийг боловсруулан хэрэгжүүлэх | • Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын тоо нэмэгдэж, зээлийн эргэн төлөлт нэмэгдсэн байна.<br>• Бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдөөс тухайн жилд их, дээд сургуульд элсэгчид 11.0 хувиар буурч 70.0 хувьд хүрсэн байна.<br>• Их, дээд сургуульд шинээр элсэгч бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн хувь 5.2 хувиар буурч 70.0 хувьд, бусад элсэгчдийн хувь 5.2 хувиар нэмэгдэж 30.0 хувьд хүрсэн байна.<br>• Их, дээд сургуулийн менежментийн чадавхи сайжирсан байна. |
| 3.2. Их, дээд сургуульд суралцагчдын нийгмийн хамгааллын бодлого, менежментийг боловсронгуй болгох | 3.2.1. Төрийн зээлийн тогтолцооны хууль эрх зүйн орчинг сайжруулах<br>3.2.2. Оюутны ирээдүйн орлогод ногдох зээлийн загварыг хэрэгжүүлэх<br>3.2.3. Их, дээд сургуульд суралцаж байгаа өнчин, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад төрийн тусламж олгох журам боловсруулж хэрэгжүүлэх<br>3.2.4. Оюутнуудад зориулсан оюутны байр, хотхон байгуулах, санаачилга, хотхоны хэлбэрээр үйл ажиллагаагаа цогц явуулах их, дээд сургуулийг дэмжих<br>3.2.5. Оюутанд хөнгөлөлттэй үйлчлэх үйлчилгээний хүрээг өргөжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх | • Оюутанд үзүүлэх зээл, тусламж үр ашигтай болсон байна.<br>• Зээл эргэн төлөгдөх баталгаатай болсон байна.<br>• Оюутнуудын нийгмийн хамгааллын бодлого бий болсон байна.<br>• Оюутнууд сургалтын төлбөрийн төдийгүй амьжиргааны зардлын зээл авах боломж бий болсон байна. |

| | |
|---|---|
| Дам үр дүн ба шалгуур үзүүлэлт | Монгол Улсын дээд боловсролын өрсөлдөх чадвар, үнэлэмж дээшилнэ. |
| | Дээд боловсролын хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлж, стандарт, магадлан итгэмжлэлийг хөгжүүлснээр иргэдэд чанартай дээд боловсрол эзэмших, тасралтгүй суралцах боломж нэмэгдэнэ |
| | Монгол Улсын мэргэжилтэй боловсон хүчний чадавхи бэхжиж үндэсний эдийн засгийн өсөлтөд үр нөлөөгөө үзүүлнэ. |
| | Их, дээд сургуулийн сургалт үндэсний эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцсэн байна. |
| | Оюутны нийгмийн хамгаалал, суралцах боломж өргөжсөн байна. |

## V БҮЛЭГ
## ХЭРЭГЦЭЭ, САНХҮҮГИЙН ТООЦОО

### 5.1. Боловсролын хэрэгцээний тооцоо

#### 5.1.1. Тооцооны үл хамаарах хувьсагч

- Мянганы хөгжлийн болон бүх нийтийн боловсролын талаар дэвшүүлсэн дэлхий нийтийн зорилтууд, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах, хүний аюулгүй байдал, хөгжлийн талаархи үндэсний зорилтуудад үндэслэн дэвшүүлсэн "Боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-ний зорилго, товлосон зорилтууд нь энэхүү мастер төлөвлөгөөний хэрэгцээ, санхүүгийн тооцооны үл хамаарах хувьсагч нь болно.

Мөн дор дурдсан нөхцөлүүд нь Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд бий болох боловсролын хэрэгцээ, санхүүг тодорхойлох тооцооны үл хамаарах хувьсагч болно. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдэд 2005-2007 онд 2-7 настай, 2008-2015 онд 2-5 настай хүүхдүүд байна.
- Сургуульд элсэх хуулийн нас 2005 оноос 7 нас, 2008 оноос 6 нас байна.
- Ерөнхий боловсролын сургуулийг 2005-2007 оны хугацаанд 5+4+2 (5 жилийн бага боловсрол, 4 жилийн дунд анги, 2 жилийн ахлах анги; 9 жилийн суурь боловсрол) гэсэн сургалтын тогтолцоо бүхий 11 жилийн сургуулийн системтэй, 2008 оноос 5+4+3 сургалтын тогтолцоо бүхий 12 жилийн сургуулийн системтэй байна.
- Бага боловсрол олгох хүүхдийн нас 2005-2007 онд 7-11 нас, 2008-2015 онд 6-10 нас байна.
- Дунд ангид суралцах хүүхдийн нас 2005-2007 онд 12-15 нас, 2008-2015 онд 11-14 нас байна.
- Ахлах ангид суралцах хүүхдийн нас 2005-2007 онд 16-17 нас, 2008-2015 онд 15-17 нас байна.

Хүснэгт 1. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын бага, дунд, ахлах ангийн хүүхдийн нас

| | 2005-2007 | 2008-2015 |
|---|---|---|
| Сургуулийн өмнөх боловсрол олгох нас | 2-6 | 2-5 |
| Бага боловсрол олгох нас | 7-11 | 6-10 |
| Дунд ангийн хүүхдийн нас | 12-15 | 11-14 |
| Ахлах ангийн хүүхдийн нас | 16-17 | 15-17 |

- Ерөнхий боловсрол, МСҮТ-ийн бүх сурагч хичээл бүрийн нэг сурах бичигтэй байна.
- Бага боловсролын багшийн 7 хоногийн цагийн норм 19, сурагчийн 7 хоногийн хичээлийн дундаж цаг 25 байна.
- ЕБС-ийн дунд, ахлах ангийн багшийн 7 хоногийн цагийн норм 19, сурагчийн 7 хоногийн хичээлийн дундаж цаг 36 байна.
- Цэцэрлэг, ЕБС, МСҮТ-д үзэх хичээлийн тоог боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу тооцно.

#### 5.1.2. Боловсролын нийт суралцагчдын хэтийн төлөв

Хүснэгт 2. СӨБ-д хамрагдах хүүхэд

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт суралцагчид (хичээлийн жилээр) | 112,477 | 103,374 | 122,562 | 136,142 |
| Үүнээс: Цэцэрлэгийн хүүхэд | 81,889 | 63,173 | 74,899 | 83,198 |
| СӨБ-ын бусад хэлбэрийн сургалтад хамрагдсан хүүхдийн тоо | 30,588 | 40,201 | 47,663 | 52,944 |
| Цэцэрлэгийн хамран сургалт (санхүүгийн жилээр) | 81,499 | 78,290 | 73,698 | 82,113 |
| Үүнээс: Төрийн өмчийн цэцэрлэг | 77,798 | 74,053 | 68,944 | 73,902 |
| Хувийн өмчийн цэцэрлэг | 3,701 | 4,237 | 4,754 | 8,211 |
| СӨБ-ын бусад хэлбэрийн сургалтын хамран сургалт (санхүүгийн жилээр) | 27,340 | 40,487 | 46,898 | 52,253 |
| Үүнээс: Хувьсах зардал олгох хүүхдийн тоо | 13,670 | 20,244 | 23,449 | 26,127 |
| СӨБ-ын хувьсах зардал олгох нийт суралцагчид | 95,169 | 98,534 | 97,147 | 108,240 |

Хүснэгт 3. Бага боловсрол олгох ангийн суралцагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Хотын суралцагчид | 158,476 | 164,951 | 162,350 | 132,300 |
| Үүнээс: Эрэгтэй | 79,233 | 82,436 | 78,550 | 65,904 |
| Эмэгтэй | 79,243 | 82,515 | 83,800 | 66,396 |
| Хөдөөгийн суралцагчид | 104,542 | 104,739 | 97,636 | 71,238 |
| Үүнээс: Эрэгтэй | 52,391 | 52,422 | 47,323 | 35,485 |
| Эмэгтэй | 52,151 | 52,317 | 50,313 | 35,753 |
| Нийт суралцагчид (хичээлийн жилээр) | 263,018 | 269,690 | 259,986 | 203,538 |
| Үүнээс: Эрэгтэй | 131,624 | 134,858 | 125,873 | 101,389 |
| Эмэгтэй | 131,394 | 134,832 | 134,113 | 102,149 |
| Нийт суралцагчид (санхүүгийн жилээр) | 252,540 | 264,603 | 276,843 | 205,039 |
| Үүнээс: Төрийн | 247,925 | 238,143 | 249,159 | 184,535 |
| Хувийн | 14,615 | 26,460 | 27,684 | 20,504 |

Хүснэгт 4. Ерөнхий дунд боловсролын дунд, ахлах ангийн суралцагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Ерөнхий боловсролын дунд анги | | | | |
| Хотын суралцагчид | 143,426 | 138,866 | 128,258 | 129,910 |
| Үүнээс: Эрэгтэй | 69,699 | 67,467 | 62,409 | 63,020 |
| Эмэгтэй | 73,727 | 71,399 | 65,849 | 66,890 |
| Хөдөөгийн суралцагчид | 79,141 | 76,116 | 70,233 | 69,952 |
| Үүнээс: Эрэгтэй | 38,492 | 37,007 | 34,189 | 33,934 |
| Эмэгтэй | 40,649 | 39,109 | 36,044 | 36,018 |
| Нийт суралцагчид | 222,567 | 214,982 | 198,491 | 199,862 |
| Үүнээс: Эрэгтэй | 108,191 | 104,474 | 96,598 | 96,954 |
| Эмэгтэй | 114,376 | 110,508 | 101,893 | 102,908 |
| Суралцагчид (санхүүгийн жилээр) | 215,483 | 218,749 | 192,402 | 209,986 |
| Үүнээс: Төрийн | 204,314 | 196,874 | 173,162 | 188,987 |
| Хувийн | 11,169 | 21,875 | 19,240 | 20,999 |
| Ерөнхий боловсролын ахлах анги | | | | |
| Хотын суралцагчид | 60,542 | 74,126 | 73,045 | 87,663 |
| Үүнээс: Эрэгтэй | 26,475 | 32,408 | 31,920 | 38,294 |
| Эмэгтэй | 34,067 | 41,718 | 41,125 | 49,369 |
| Хөдөөгийн суралцагчид | 21,540 | 26,004 | 25,247 | 29,220 |
| Үүнээс: Эрэгтэй | 9,375 | 11,328 | 11,001 | 12,764 |
| Эмэгтэй | 12,165 | 14,676 | 14,246 | 16,456 |
| Ерөнхий боловсролын дунд, ахлах анги | | | | |
| Нийт суралцагчид | 82,082 | 100,130 | 98,292 | 116,883 |
| Үүнээс: Эрэгтэй | 35,850 | 43,736 | 42,921 | 51,058 |
| Эмэгтэй | 46,232 | 56,394 | 55,371 | 65,825 |
| Нийт суралцагчид (санхүүгийн жилээр) | 83,436 | 94,804 | 96,180 | 97,052 |
| Үүнээс: Төрийн | 78,560 | 88,561 | 89,044 | 87,347 |
| Хувийн | 4,876 | 6,243 | 7,136 | 9,705 |

Хүснэгт 5. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны суралцагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| ЕБС-ийн (1-12) дотуур байрны суралцагчид (хичээлийн жилээр) | 43,743 | 50,376 | 58,015 | 82,573 |
| Үүнээс: Хөдөөгийн малчдын хүүхдийн тоо | 17,366 | 23,050 | 30,570 | 61,929 |

Хүснэгт 6. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын суралцагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Хотын суралцагчид | 18,843 | 19,625 | 22,445 | 32,710 |
| Үүнээс: Эрэгтэй | 12,282 | 13,655 | 15,235 | 17,699 |
| Эмэгтэй | 6,561 | 5,970 | 7,210 | 15,011 |
| Хөдөөгийн суралцагчид | 1,330 | 1,374 | 1,451 | 1,677 |
| Үүнээс: Эрэгтэй | 978 | 1,017 | 1,043 | 956 |
| Эмэгтэй | 352 | 357 | 408 | 721 |
| Нийт суралцагчид | 20,173 | 20,999 | 23,896 | 34,387 |
| Үүнээс: Эрэгтэй | 13,260 | 14,672 | 16,278 | 18,655 |
| Эмэгтэй | 6,913 | 6,327 | 7,618 | 15,732 |
| Нийт суралцагчид (санхүүгийн жилээр) | 21,126 | 20,684 | 22,787 | 34,961 |
| Үүнээс: Төрийн | 20,780 | 20,130 | 21,789 | 29,717 |
| Хувийн | 346 | 554 | 998 | 5,244 |

Хүснэгт 7. МСҮТ-ийн дотуур байрны суралцагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын дотуур байрны суралцагчид | 3,340 | 3,621 | 4,416 | 8,740 |

Хүснэгт 8. Бичиг үсгийн болон албан бус боловсролын суралцагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт суралцагчид | 11,478 | 9,092 | 11,591 | 21,698 |
| Эрэгтэй | 6,193 | 5,065 | 6,215 | 10,451 |
| Эмэгтэй | 5,285 | 4,027 | 5,376 | 11,167 |

Хүснэгт 9. Албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтын суралцагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчид | 3899 | 3089 | 2503 | 894 |
| Бага боловсрол | 2608 | 1985 | 1679 | 574 |
| Ерөнхий боловсролын дунд анги | 1291 | 1104 | 824 | 320 |

Хүснэгт 10. Дээд боловсролын суралцагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт суралцагчид | 129,924 | 131,339 | 149,154 | 149,119 |
| Үүнээс: Нийгэм хүмүүнлэгийн ухаан | 21,489 | 19,425 | 19,726 | 14,912 |
| Хууль | 7,054 | 6,663 | 7,070 | 5,965 |
| Байгалийн шинжлэл | 3,987 | 4,275 | 5,150 | 5,965 |
| Багш | 12,772 | 12,960 | 14,774 | 14,912 |
| Инженер, технологи | 19,380 | 21,974 | 27,989 | 37,280 |
| Анагаах ухаан | 9,875 | 9,802 | 10,929 | 10,438 |
| Хөдөө аж ахуй | 4,556 | 5,190 | 6,641 | 8,947 |
| Бусад | 49,270 | 48,613 | 53,883 | 50,700 |
| Суралцагчид (санхүүгийн жилээр) | 124,241 | 129,750 | 143,821 | 158,780 |
| Үүнээс: Төрийн | 86,476 | 91,987 | 103,742 | 119,085 |
| Хувийн | 37,765 | 37,763 | 40,079 | 39,695 |
| Төрийн сургалтын сангаас сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох оюутны тоо | 46204 | 46204 | 46204 | 46204 |
| Үүнээс: Нийгэм хүмүүнлэгийн ухаан | 2,265 | 2,265 | 2,265 | 2,265 |
| Хууль | 906 | 906 | 906 | 906 |
| Байгалийн шинжлэл | 2,718 | 2,718 | 2,718 | 2,718 |
| Багш | 6,795 | 6,795 | 6,795 | 6,795 |
| Инженер, технологи | 16,987 | 16,987 | 16,987 | 16,987 |
| Анагаах ухаан | 4,756 | 4,756 | 4,756 | 4,756 |
| Хөдөө аж ахуй | 4,077 | 4,077 | 4,077 | 4,077 |
| Бусад | 7,700 | 7,700 | 7,700 | 7,700 |

### 5.1.3. Боловсролын салбарын багш ба багш бус ажиллагчдын хэтийн төлөв

Хүснэгт 11. СӨБ-ын багш ба багш бус ажиллагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт шаардлагатай багш (1а+1б+1в) | 4,593 | 5,234 | 5,316 | 5,837 |
| Үүнээс: Багш (1а) | 4,182 | 4,798 | 4,854 | 5,306 |
| Арга зүйч багш (1б) | 119 | 123 | 128 | 143 |
| Хөгжмийн багш (1в) | 292 | 313 | 334 | 389 |
| Нийт шаардлагатай туслах багш | 3,044 | 3,182 | 3,036 | 3,465 |
| Нийт ажиллах багш 1а+1б+1в (санхүүгийн жилээр) | 4,476 | 5,099 | 5,316 | 5,770 |
| Үүнээс: Төрийн | 4,226 | 4,775 | 4,954 | 5,193 |
| Хувийн | 250 | 324 | 362 | 577 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Нийт ажиллах туслах багш (санхүүгийн жилээр) | 2,983 | 3,219 | 3,036 | 3,408 |
| Үүнээс: Төрийн | 2,817 | 3,016 | 2,834 | 3,067 |
| Хувийн | 166 | 203 | 202 | 341 |
| Нийт ажиллах багш бус ажиллагчид (санхүүгийн жилээр) | 4,674 | 4,673 | 4,617 | 4,670 |
| Үүнээс: Төрийн | 4,414 | 4,378 | 4,285 | 4,202 |
| Хувийн | 260 | 295 | 332 | 468 |

Хүснэгт 12. Бага боловсролын багш ба багш бус ажиллагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Хотод | | | | |
| Нийт ажиллах багш | 4,550 | 4,694 | 4,752 | 4,836 |
| Нийт шаардлагатай багш бус ажиллагчид | 1,738 | 1,738 | 1,721 | 1,636 |
| Сургалтын төлөвлөгөө ёсоор шаардагдах багшийн тоо | 5,971 | 6,173 | 6,035 | 4,836 |
| Хөдөөд | | | | |
| Нийт ажиллах багш | 3,201 | 3,178 | 3,132 | 3,124 |
| Нийт шаардлагатай багш бус ажиллагчид | 2,453 | 2,428 | 2,404 | 2,286 |
| Сургалтын төлөвлөгөө ёсоор шаардагдах багшийн тоо | 4,481 | 4,513 | 4,228 | 3,124 |
| Нийт дүн | | | | |
| Нийт шаардлагатай багш | 7,751 | 7,872 | 7,884 | 7,960 |
| Нийт шаардлагатай багш бус ажиллагчид | 4,191 | 4,166 | 4,125 | 3,922 |
| Сургалтын төлөвлөгөө ёсоор шаардагдах багшийн тоо | 10,452 | 10,686 | 10,263 | 7,960 |
| Нийт ажиллах багш (санхүүгийн жилээр) | 10,442 | 10,495 | 10,942 | 8,029 |
| Үүнээс: Төрийн | 9,707 | 9,445 | 9,848 | 7,226 |
| Хувийн | 735 | 1,050 | 1,094 | 803 |
| Багш бус ажиллагчид (санхүүгийн жилээр) | 4,208 | 4,166 | 4,152 | 3,949 |
| Үүнээс: Төрийн | 3,912 | 3,749 | 3,737 | 3,554 |
| Хувийн | 295 | 417 | 415 | 395 |

Хүснэгт 13. Ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн багш ба багш бус ажиллагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Хотод | | | | |
| Нийт шаардлагатай багш | 9,418 | 9,769 | 9,969 | 10,559 |
| Нийт шаардлагатай багш бус ажиллагчид | 3,783 | 3,708 | 3,634 | 3,456 |
| Сургалтын төлөвлөгөө ёсоор шаардагдах багшийн тоо | 11,349 | 12,016 | 11,514 | 12,882 |
| Хөдөөд | | | | |
| Нийт шаардлагатай багш | 5,314 | 5,584 | 5,875 | 6,331 |
| Нийт шаардлагатай багш бус ажиллагчид | 3,730 | 3,655 | 3,583 | 3,408 |
| Сургалтын төлөвлөгөө ёсоор шаардагдах багшийн тоо | 6,270 | 6,478 | 6,169 | 6,711 |
| Нийт дүн | | | | |
| Нийт шаардлагатай багш | 14,732 | 15,353 | 15,844 | 16,890 |
| Нийт шаардлагатай багш бус ажиллагчид | 7,513 | 7,364 | 7,217 | 6,864 |
| Сургалтын төлөвлөгөө ёсоор шаардагдах багшийн тоо | 17,619 | 18,494 | 17,683 | 19,593 |
| Нийт ажиллах нийт багш (санхүүгийн жилээр) | 17,199 | 18,313 | 17,106 | 18,912 |
| Үүнээс: Төрийн | 15,399 | 15,566 | 14,540 | 16,075 |
| Хувийн | 1,800 | 2,747 | 2,566 | 2,837 |
| Багш бус ажиллагчид (санхүүгийн жилээр) | 7,564 | 7,413 | 7,266 | 6,910 |
| Үүнээс: Төрийн | 6,918 | 6,672 | 6,539 | 5,219 |
| Хувийн | 646 | 741 | 727 | 691 |

Хүснэгт 14. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын багш ба бусад ажиллагсад

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Хотод | | | | |
| Нийт шаардлагатай багш | 1,031 | 1,122 | 1,341 | 2,181 |
| Нийт шаардлагатай багш бус ажиллагчид | 644 | 577 | 571 | 935 |
| Сургалтын төлөвлөгөө ёсоор шаардагдах багшийн тоо | 1256 | 1309 | 1497 | 2181 |
| Хөдөөд | | | | |
| Нийт шаардлагатай багш | 77 | 82 | 90 | 112 |
| Нийт шаардлагатай багш бус ажиллагчид | 56 | 56 | 57 | 60 |
| Сургалтын төлөвлөгөө ёсоор шаардагдах багшийн тоо | 88 | 91 | 97 | 112 |
| Нийт дүн | | | | |
| Нийт шаардлагатай багш | 1108 | 1204 | 1431 | 2293 |
| Нийт шаардлагатай багш бус ажиллагчид | 700 | 633 | 632 | 995 |
| Сургалтын төлөвлөгөө ёсоор шаардагдах багшийн тоо | 1,344 | 1,400 | 1,594 | 2,293 |
| Нийт ажиллах багш (санхүүгийн жилээр) | 1,407 | 1,379 | 1,519 | 2,331 |
| Үүнээс: Төрийн | 1,353 | 1,172 | 1,291 | 1,981 |
| Хувийн | 54 | 207 | 228 | 350 |
| Нийт ажиллах багш бус ажиллагчид (санхүүгийн жилээр) | 772 | 654 | 629 | 999 |
| Үүнээс: Төрийн | 742 | 556 | 535 | 849 |
| Хувийн | 30 | 98 | 94 | 150 |

Хүснэгт 15. Албан бус боловсролын багш ба багш бус ажиллагчид

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт шаардлагатай багш | 459 | 364 | 464 | 865 |
| Нийт шаардлагатай багш бус ажиллагчид | 87 | 66 | 79 | 130 |

5.1.4. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, барилгын хэрэгцээний хэтийн төлөв

Хүснэгт 16. СӨБ-ын сургалтын хэрэглэгдэхүүн, багшийн гарын авлага

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Цэцэрлэг | | | | |
| Ном, сургалтын материал | 327,556 | 252,692 | 299,596 | 332,792 |
| Багшийн гарын авлага | 26,160 | 26,748 | 25,344 | 28,228 |
| СӨБ-ын бусад хэлбэрийн сургалт | | | | |
| Ном, сургалтын материал | 122,352 | 160,804 | 190,652 | 211,776 |
| Багшийн гарын авлага | 4,388 | 6,916 | 8,064 | 8,980 |
| Нийт | | | | |
| Ном, сургалтын материал | 449,908 | 413,496 | 490,248 | 544,568 |
| Багшийн гарын авлага | 30,548 | 33,664 | 33,408 | 37,208 |

Хүснэгт 17. Бага боловсролын сурах бичиг, багшийн гарын авлага

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт сурах бичиг | 2,008,996 | 2,042,706 | 2,079,654 | 1,590,258 |
| I анги | 364,386 | 357,528 | 256,476 | 241,284 |
| II анги | 412,800 | 345,882 | 262,638 | 242,952 |
| III анги | 213,168 | 473,440 | 469,936 | 326,072 |
| IY анги | 447,912 | 602,046 | 509,814 | 367,020 |
| Y анги | 570,730 | 263,810 | 580,790 | 412,930 |
| Эмэгтэй бүлгийн хүүхдэд эзэмшүүлэх сурах бичиг | 233,219 | 229,400 | 225,935 | 159,026 |
| I анги | 42,301 | 40,151 | 27,864 | 24,128 |
| II анги | 47,921 | 38,843 | 28,533 | 24,295 |
| III анги | 24,746 | 53,168 | 51,054 | 32,607 |
| IY анги | 51,997 | 67,611 | 55,386 | 36,702 |
| Y анги | 66,254 | 29,626 | 63,097 | 41,293 |

Хүснэгт 18. ЕБС-ийн дунд ангийн сурах бичиг, багшийн гарын авлага

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт сурах бичиг | | | | |
| Сурах бичиг | 3,114,232 | 3,019,940 | 2,752,022 | 2,828,275 |
| YI анги | 689,976 | 592,668 | 795,360 | 505,188 |
| YII анги | 724,906 | 792,722 | 371,042 | 607,012 |
| YIII анги | 822,075 | 857,445 | 737,490 | 866,190 |
| IX анги | 877,275 | 777,105 | 848,130 | 849,885 |
| Эмзэг бүлгийн хүүхдэд эзэмшүүлэх сурах бичиг | 361,523 | 339,146 | 298,981 | 282,828 |
| YI анги | 80,097 | 66,558 | 86,408 | 50,519 |
| YII анги | 84,152 | 89,024 | 40,310 | 60,701 |
| YIII анги | 95,432 | 96,293 | 80,121 | 86,619 |
| IX анги | 101,840 | 87,271 | 92,141 | 84,989 |

Хүснэгт 19. ЕБС-ийн ахлах ангийн сурах бичиг, багшийн гарын авлага

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт сурах сурах бичиг | 1,067,060 | 1,301,690 | 1,277,796 | 1,519,479 |
| X анги | 528,346 | 632,203 | 673,387 | 712,816 |
| XI анги | 538,714 | 669,487 | 604,409 | 806,663 |
| Эмзэг бүлгийн хүүхдэд эзэмшүүлэх сурах бичиг | 106,706 | 130,169 | 127,780 | 151,948 |
| X анги | 52,835 | 63,220 | 67,339 | 71,282 |
| XI анги | 53,871 | 66,949 | 60,441 | 80,666 |

Хүснэгт 20. МСТБ-ын сурах бичиг, багшийн гарын авлага

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Нийт сурах бичиг | 248,430 | 269,820 | 309,150 | 448,005 |
| I анги | 132,810 | 152,670 | 184,500 | 242,370 |
| II анги | 115,620 | 117,150 | 124,650 | 205,635 |
| III анги | 25,277 | 21,077 | 23,002 | 31,640 |
| Эмзэг бүлгийн хүүхдэд эзэмшүүлэх сурах бичиг | 55,977 | 62,207 | 74,271 | 119,911 |
| I анги | 27,161 | 32,648 | 41,255 | 60,593 |
| II анги | 23,646 | 25,052 | 27,873 | 51,409 |
| III анги | 5,169 | 4,507 | 5,143 | 7,910 |

Хүснэгт 21. ЕБС, МСҮТ-ийн компьютержүүлэлт

| | 2006 | 2008 | 2010 | 2015 | 2006-2015 |
|---|---|---|---|---|---|
| Элэгдэх компьютерийн тоо | 2,080 | 3,520 | 3,769 | 12,723 | 50,034 |
| Нийт шаардагдах компьютер | 7,040 | 10,245 | 13,832 | 31,422 | 164,186 |
| Сурагч компьютерийн харьцаа (бага боловсрол) | 933 | 696 | 520 | 250 | - |
| Сурагч компьютерийн харьцаа (ЕБС-ийн дунд анги) | 187 | 139 | 104 | 50 | - |
| Сурагч компьютерийн харьцаа (ЕБС-ийн ахлах анги, МСҮТ) | 19 | 14 | 10 | 5 | - |

Хүснэгт 22. СӨБ, ЕБ, МСТБ-д шинээр шаардагдах суудал, орны тоо

| | 2006 | 2008 | 2010 | 2015 | 2006-2015 |
|---|---|---|---|---|---|
| СӨБ-д шинээр шаардагдах ор/суудал | 1,010 | 730 | 730 | 730 | 7,880 |
| ЕБС-д шинээр шаардагдах суудал | 9,576 | 4,329 | 5,275 | 8,914 | 69,607 |
| Дотуур байранд шинээр шаардагдах ор | 500 | 500 | 500 | 500 | 5,000 |
| МСТБ-д шинээр шаардагдах суудал | 600 | 600 | 400 | 200 | 3,800 |

5.2. Шаардагдах санхүүгийн тооцоо

5.2.1. Сургуулийн өмнөх боловсрол

• Хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын нормыг бага насны хүүхдийн хоолны тэжээллэг болон илчлэгийн нормд үндэслэн цэцэрлэгийн нэг хүүхдийн нэг жилийн хоолны зардлыг 72.000 төгрөг байсныг 116.000 төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны жилийн дундаж зардал 2006-2010 онд 8.7 тэрбум төгрөг, 2011-2015 онд 12.3 тэрбум төгрөг болно.

• Цэцэрлэгийн багшийн сарын дундаж цалин, хөлс 78.300 төгрөгийг жилд дунджаар 14.6 хувиар өсгөж 2015 он гэхэд 350.000 төгрөгт хүргэхээр төлөвлөсөн бөгөөд цэцэрлэгийн багш нарын цалин, хөлсөнд зарцуулах жилийн дундаж зардал 2006-2010 онд 8.3 тэрбум төгрөг, 2011-2015 онд 18.2 тэрбум төгрөг болно.

• Цэцэрлэгийн туслах багшийн сарын дундаж цалин, хөлс 63.000 төгрөгийг 11.0 хувиар өсгөж 200.000 төгрөгт хүргэхээр төлөвлөсөн бөгөөд цэцэрлэгийн туслах багш нарын цалин, хөлсөнд зарцуулах жилийн дундаж зардал 2006-2010 онд 3.6 тэрбум төгрөг, 2011-2015 онд 6.4 тэрбум төгрөг болно.

• Цэцэрлэгийн багш бус ажиллагчдын дундаж цалин, хөлс 51.100 төгрөгийг жилд дунджаар 11.0 хувиар өсгөж 2015 он гэхэд 180.000 төгрөгт хүргэхээр төлөвлөсөн бөгөөд цэцэрлэгийн багш бус ажиллагчдын цалин, хөлсөнд зарцуулах жилийн дундаж зардал 2006-2010 онд 4.5 тэрбум төгрөг, 2011-2015 онд 8.0 тэрбум төгрөг болно.

• Цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, барилга засвар зэрэг урсгал зардалтай холбоотой бусад зардал болон хөрөнгө оруулалтын зардлыг жилд 8 хуваиар өсгөнө.

Хүснэгт 23. СӨБ-ын зардлын бүтэц

(төгрөгөөр)

| | 2006-2010 дундаж | 2006-2010 нийт | 2011-2015 дундаж | 2011-2015 нийт |
|---|---|---|---|---|
| 1. Урсгал зардал | | | | |
| 1.1. Багшийн цалин, хөлс | 11,913,361 | 59,566,803 | 24,620,754 | 123,103,770 |
| Үндсэн багшийн цалин, хөлс | 8,309,309 | 41,546,544 | 18,219,235 | 91,096,177 |
| Туслах багшийн цалин, хөлс | 3,604,052 | 18,020,259 | 6,401,519 | 32,007,593 |
| 1.2. Багш бус ажиллагчдын цалин, хөлс | 4,569,210 | 22,846,048 | 8,096,479 | 40,482,395 |
| 1.3. Нийгмийн даатгал | 4,351,399 | 21,756,993 | 8,637,350 | 43,186,748 |
| 1.4. Урсгал зардал | 503,263 | 2,516,317 | 742,501 | 3,712,506 |
| 1.5. Хүүхдийн хоол | 8,790,655 | 43,953,273 | 12,389,086 | 61,945,428 |
| 1.6. Бусад хувьсах зардал | 2,745,981 | 13,729,903 | 4,398,274 | 21,991,368 |
| 1.7. Тогтмол зардал | 6,740,983 | 33,704,917 | 9,904,716 | 49,523,581 |
| Халаалт, дулаан | 4,818,470 | 24,092,349 | 7,079,913 | 35,399,565 |
| Цахилгаан, ус | 1,790,558 | 8,952,792 | 2,630,918 | 13,154,589 |
| Тээвэр, холбоо | 131,955 | 659,776 | 193,885 | 969,427 |
| 1.8. Нэг удаагийн тэтгэмж | 158,050 | 790,250 | 232,227 | 1,161,137 |
| 1. Нийт урсгал зардал | 39,772,901 | 198,864,503 | 69,021,386 | 345,106,932 |
| 2. Хөрөнгө оруулалтын зардал | 405,223 | 2,026,114 | 595,405 | 2,977,027 |
| СӨБ-ын нийт зардал | 40,178,124 | 200,890,618 | 69,616,792 | 348,083,958 |

• Төлөвлөсөн хугацаанд цэцэрлэгийн суудлыг 8000-аар нэмэгдүүлнэ. Цэцэрлэгийн барилга угсралтын зардал 2006-2010 онуудад жилд дунджаар 3,4 тэрбум төгрөг, 2011-2015 онуудад жилд дунджаар 4,4 тэрбум төгрөг болно.

• Сургуулийн өмнөх боловсролын хүүхэд, багш нарт зориулсан сургалтын гарын авлага, материалын хангамжид 2006-2010 онуудад жилд дунджаар 499.8 сая төгрөг, 2011-2015 онуудад жилд дунджаар 558.8 сая төгрөг зарцуулна..

• Цэцэрлэгийн тоглоом наадгай, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг жил бүр 8.0 хувиар өсгөх бөгөөд үүний зардалд 2006-2015 онуудад 5.3 тэрбум төгрөг, 2011-2015 онд 1.2 тэрбум төгрөг шаардагдана.

• 2006-2015 онуудад дотоодод мэргэжил дээшлүүлэхэд 1.9 тэрбум төгрөг, гадаадад мэргэжил дээшлүүлэхэд 175.0 сая төгрөгийн санхүүжилт хийснээр жил бүр сургуулийн өмнөх боловсролын багш нарын 50.0-иас доошгүй хувийг дотоодод, жил бүр 30 багшийг гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах сургалтад хамруулах боломжтой болно.

Хүснэгт 24. СӨБ-д төвлөрсөн хөрөнгө оруулалтаас олгох зардал

(төгрөгөөр)

| | 2006-2010 жилийн дундаж | 2006-2010 нийт | 2011-2015 жилийн дундаж | 2011-2015 нийт |
|---|---|---|---|---|
| Барилга угсралт | 3,380,181 | 16,900,905 | 4,352,710 | 21,763,548 |
| Шинээр шаардагдах ор/суудлын тоо | 846 | 4,230 | 730 | 3,650 |
| Цэцэрлэгийн тоглоом | 92,932 | 464,661 | 136,548 | 682,739 |
| Бусад тоног төхөөрөмж | 30,977 | 154,887 | 45,516 | 227,580 |
| Дотоодод багшийн мэргэжлийг дээшлүүлэх | 324,489 | 1,622,443 | 390,231 | 1,951,155 |
| Гадаадад багшийн мэргэжлийг дээшлүүлэх | 101,410 | 507,052 | 149,005 | 745,025 |

5.2.2. Ерөнхий боловсрол

• ЕБС-ийн 1, 2 дугаар ангийн хүүхдүүдийн нэг өдрийн цайны зардлыг 300 төгрөгөөр төлөвлөсөн. Үдийн цайны жилийн дундаж зардлыг 2006-2010 онд 4.0 тэрбум төгрөг, 2011-2015 онд 4.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн.

• ЕБС-ийн багшийн дундаж цалин, хөлс 81.500 төгрөгийг жилд дунджаар 14.2 хувиар өсгөж 2015 он гэхэд 350.000 төгрөгт хүргэхээр төлөвлөсөн бөгөөд ЕБС-ийн багшийн цалин, хөлсөнд зарцуулах жилийн дундаж зардал 2006-2010 онд 42.0 тэрбум төгрөг, 2011-2015 онд 77.3 тэрбум төгрөг болно.

• ЕБС-ийн багш бус ажиллагчдын дундаж цалин, хөлс 82.300 төгрөгийг жилд дунджаар 10.6 хувиар өсгөж 2015 он гэхэд 250.000 төгрөгт хүргэхээр төлөвлөсөн бөгөөд ЕБС-ийн багш, багш бус ажиллагчдын цалин, хөлсөнд зарцуулах жилийн дундаж зардал 2006-2010 онд 17.2 тэрбум төгрөг, 2011-2015 онд 27.3 тэрбум төгрөг болно.

• ЕБС-ийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, дотуур байрны нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, барилга засвар зэрэг урсгал зардалтай холбоотой бусад зардал болон хөрөнгө оруулалтын зардлыг жилд 8 хувиар өсгөхөөр тооцсон.

Хүснэгт 25. Бага, дунд боловсролын зардлын бүтэц

(төгрөгөөр)

| | 2006-2010 дундаж | 2006-2010 нийт | 2011-2015 дундаж | 2011-2015 нийт |
|---|---|---|---|---|
| 1. Урсгал зардал | | | | |
| 1.1. Багшийн цалин, хөлс | 42,095,144 | 210,475,721 | 77,376,623 | 386,883,115 |
| Багшийн цалин хөлс | 42,095,144 | 210,475,721 | 77,376,623 | 386,883,115 |
| 1.2. Бусад багш бус ажиллагчдын цалин, хөлс | 17,288,581 | 86,442,904 | 27,381,630 | 136,908,152 |
| 1.3. Нийгмийн даатгал | 15,677,303 | 78,386,517 | 27,656,179 | 138,280,895 |
| 1.4. I-II ангийн хүүхдийн үдийн цай | 4,087,337 | 20,436,683 | 4,518,260 | 22,591,299 |
| 1.5. Урсгал засвар | 1,532,493 | 7,662,467 | 2,047,985 | 10,239,926 |
| 1.6. Бусад хувьсах зардал | 8,024,044 | 40,120,220 | 11,095,129 | 55,475,643 |
| 1.7. Дотуур байрны сурагчдын хувьсах зардал | 6,493,101 | 32,465,503 | 13,578,993 | 67,894,966 |
| 1.8. Тогтмол зардал | 18,179,785 | 90,898,924 | 26,712,068 | 133,560,341 |
| Халаалт, дулаан | 14,849,428 | 74,247,139 | 21,818,681 | 109,093,406 |
| Ус, цахилгаан | 2,817,705 | 14,088,523 | 4,140,132 | 20,700,662 |
| Тээвэр, холбоо | 512,652 | 2,563,262 | 753,255 | 3,766,273 |
| 1. Нийт урсгал зардал | 113,377,788 | 566,888,939 | 190,366,867 | 951,834,336 |
| 2. Хөрөнгө оруулалтын зардал | 1,243,631 | 6,218,157 | 1,827,303 | 9,136,513 |
| Нийт зардал | 114,621,419 | 573,107,096 | 192,194,170 | 960,970,850 |

• 2006-2015 онд ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоог 69,6 мянгаар нэмэгдүүлэх хэрэгцээ бий болж байна. ЕБС-ийн 69,6 мянган суудал бүхий хичээлийн шинэ байр, өргөтгөлийг барихад 2006-2015 онд нийтдээ 204.5 тэрбум төгрөгийн хэрэгцээ үүсч байгаа бөгөөд 2006-2010 онуудад жилд дунджаар 15.2 тэрбум төгрөг, 2011-2015 онуудад жилд дунджаар 25.7 тэрбум төгрөг тус тус шаардагдана.

• Мастер төлөвлөгөөнд тусгасан зорилтыг хэрэгжүүлэхэд 2006-2015 онд дотуур байрны хүчин чадлыг жил бүр 500 ороор нэмэгдүүлэх шаардлага үүсч байна. Энэ арга хэмжээний санхүүжилтэд 2006-2010 онуудад жилд дунджаар 2.4 тэрбум төгрөг, 2011-2015 онуудад жилд дунджаар 3.5 тэрбум төгрөг тус тус төлөвлөсөн.

• Ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй эмзэг бүлгийн сурагчдад хичээлийн сурах бичгийг

үнэ төлбөргүй эзэмшүүлэх зардалд 2006-2010 онд жилд дунджаар 1.9 тэрбум төгрөг, 2011-2015 онуудад жилд дунджаар 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдаж байна.

• Ерөнхий боловсролын сургуулийг компьютержүүлэхэд 2006-2015 онуудад нийтдээ 42 тэрбум (жилд дунджаар 4.2 тэрбум) төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөж байна. Үүнд: Бага боловсролын хүүхэд компьютерийн харьцааг 1250-иас 250 (250 хүүхэдэд нэг компьютер), дунд ангийн хүүхэд компьютерийн харьцааг 250-иас 50, ахлах ангийн хүүхэд компьютерийн харьцааг 25-аас 5-д хүргэнэ.

• Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний санхүүжилтийг жил бүр 8 хувиар нэмэгдүүлснээр 2006-2015 онуудад 732.4 сая төгрөгийн санхүүжилтийг хийхээр төлөвлөсөн.

• 2005-2015 онуудад дотоодод мэргэжил дээшлүүлэхэд 19.4 тэрбум төгрөг, гадаадад мэргэжил дээшлүүлэхэд 8.9 тэрбум төгрөгийн санхүүжилт хийснээр жил бүр ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 50.0-иас доошгүй хувийг дотоодод, 200 багшийг гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах сургалтад хамруулах боломжийг бий болгоно.

Хүснэгт 26. Бага, дунд боловсролд төвлөрсөн хөрөнгө оруулалтаас олгох зардал

(төгрөгөөр)

| | 2006- 2010 дундаж | 2006- 2010 нийт | 2011- 2015 дундаж | 2011- 2015 нийт |
|---|---|---|---|---|
| Хичээлийн байрны барилга угсралт | 15,211,604.5 | 76,058,022.7 | 25,688,262.7 | 128,441,313.6 |
| Шинээр шаардагдах суудлын тоо | 6,644 | 33,219 | 7,278 | 36,388 |
| Дотуур байрны барилга угсралт | 2,361,998.8 | 11,809,994.3 | 3,470,551.2 | 17,352,756.2 |
| Шинээр шаардагдах орны тоо | 500 | 2,500 | 500 | 2,500 |
| Компьютер | 3,301,705.6 | 16,508,528.2 | 5,103,900.8 | 25,519,504.3 |
| Бусад тоног төхөөрөмж | 55,759.27 | 278,796.3 | 81,928.6 | 409,643.2 |
| Дотоодод багшийн мэргэжлийг дээшлүүлэх | 1,706,073.8 | 8,530,369.3 | 1,872,643.9 | 9,363,219.8 |
| Гадаадад багшийн мэргэжлийг дээшлүүлэх | 676,068.9 | 3,380,344.8 | 993,367.1 | 4,966,835.6 |
| ЕБС-ийн эмзэг бүлгийн суралцагчдад олгох сурах бичиг | 1,917,960.7 | 9,589,803.5 | 1,702,867.9 | 8,514,339.4 |

5.2.3. Мэргэжлийн сургалт, техникийн боловсрол

• МСТБ-ын багшийн дундаж цалин, хөлс 77.200 төгрөгийг жилд дунджаар 16.1 хувиар өсгөж 2015 он гэхэд 400.000 төгрөгт хүргэхээр төлөвлөсөн бөгөөд МСТБ-ын багшийн цалин, хөлсөнд зарцуулах жилийн дундаж зардал 2006-2010 онд 2.4 тэрбум төгрөг, 2011-2015 онд 7.3 тэрбум төгрөг болно.

• МСТБ-ын багш бус ажиллагчдын дундаж цалин, хөлс 68.200 төгрөгийг жилд дунджаар 11.2 хувиар өсгөж 2015 он гэхэд 220.000 төгрөгт хүргэхээр төлөвлөсөн бөгөөд МСТБ -ын багш, багш бус ажиллагыдын цалин, хөлсөнд зарцуулах жилийн дундаж зардал 2006-2010 онд 846.3 сая төгрөг, 2011-2015 онд 1.8 тэрбум төгрөг болно.

• МСТБ-д сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хөрөнгө оруулалтын зардлыг тусад нь төлөвлөж байгаагүй бөгөөд 2006 онд 1,0 тэрбум төгрөг улсын төсөвт төлөвлөгдсөн. МСТБ--ын хөрөнгө оруулалтад 2006 онд олгохоор төлөвлөсөн санхүүжилтийг цаашид жил бүр 8 хувиар нэмэгдүүлэн санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

• МСТБ-ын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг жил бүр 10 хувиар нэмэгдүүлэхээр тооцоог хийсэн.

Хүснэгт 27. МСТБ-ын зардлын бүтэц

(төгрөгөөр)

| | 2006-2010 дундаж | 2006-2010 нийт | 2011-2015 дундаж | 2011-2015 нийт |
|---|---|---|---|---|
| 1. Урсгал зардал | | | | |
| 1.1. Багшийн цалин хөлс | 2,457,420 | 12,287,100 | 7,347,490 | 36,737,450 |
| 1.2. Багш бус ажиллагчдын цалин хөлс | 846,337 | 4,231,684 | 1,800,380 | 9,001,902 |
| 1.3. Нийгмийн даатгал | 872,192 | 4,360,959 | 2,415,038 | 12,075,189 |
| 1.4. Бусад хувьсах зардал | 2,257,309 | 11,286,545 | 5,107,778 | 25,538,889 |
| 1.5. Дотуур байрны суралцагчдын хувьсах Зардал | 624,744 | 3,123,720 | 1,670,584 | 8,352,920 |
| 1.6. Тогтмол зардал | 1,768,379 | 8,841,893 | 3,359,206 | 16,796,030 |
| Халаалт, дулаан | 1,208,575 | 6,042,873 | 2,295,804 | 11,479,022 |
| Цахилгаан, ус | 464,359 | 2,321,793 | 882,094 | 4,410,470 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Тээвэр, холбоо | 95,445 | 477,227 | 181,308 | 906,539 |
| 1. Нийт урсгал зардал | 8,826,380 | 44,131,901 | 21,700,476 | 108,502,381 |
| 2. Хөрөнгө оруулалтын зардал | 1,267,186 | 6,335,929 | 1,861,912 | 9,309,558 |
| Нийт зардал | 10,093,566 | 50,467,830 | 23,562,388 | 117,811,939 |

• 2006-2015 онд мэргэжлийн анхан, дунд боловсрол олгох сургуулийн 3800 суудал бүхий хичээлийн байрыг шинээр барихад 2006-2010 онуудад жилд дунджаар 2,7 тэрбум төгрөг, 2011-2015 онуудад жилд дунджаар 1,8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр төлөвлөсөн.

• Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын лабораторийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг жил бүр 10.0 хувиар өсгөхөөр төлөвлөж байгаа нь 2006-2010 онуудад жилд дунджаар 113.7 сая төгрөг, 2011-2015 онуудад жилд дунджаар 183.1 сая төгрөгийн санхүүжилт шаардагдаж байна.

• Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын эмзэг бүлгийн суралцагчдад сурах бичиг, сургалтын гарын авлагыг номын сангаар дамжуулан үнэ төлбөргүй эзэмшүүлэх зардалд 2006-2010 онд жилд дунджаар 178.1 сая төгрөг, 2011-2015 онуудад жилд дунджаар 289.8 сая төгрөгийн санхүүжилт шаардагдаж байна.

• 2006-2015 онуудад дотоодод мэргэжил дээшлүүлэхэд 4.4 тэрбум төгрөг, гадаадад мэргэжил дээшлүүлэхэд 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилт хийснээр мэргэжлийн сургалт, техникийн боловсролын багш нарын 50.0-иас доошгүй хувийг дотоодод, жил бүр 20 багшийг гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах сургалтад хамруулах боломж бий болно.

Хүснэгт 28. Бага, дунд боловсролд төвлөрсөн хөрөнгө оруулалтаас олгох зардал

(төгрөгөөр)

| | 2006-2010 жилийн дундаж | 2006-2010 нийт | 2011-2015 жилийн дундаж | 2011-2015 нийт |
|---|---|---|---|---|
| Барилга угсралт | 2,653,665 | 13,268,325 | 1,787,336.8 | 8,936,684 |
| Шинээр шаардагдах суудлын тоо | 520 | 2,600 | 240 | 1,200 |
| Тоног төхөөрөмж | 113,702 | 568,509 | 183,118.0 | 915,590 |
| Дотоодод багшийн мэргэжлийг дээшлүүлэх | 374,721 | 1,873,604 | 425,689.4 | 2,128,447 |
| Гадаадад багшийн мэргэжлийг дээшлүүлэх | 84,509 | 422,543 | 124,170.9 | 620,854 |
| МСТБ–ын эмзэг бүлгийн суралцагчдад олгох сурах бичиг | 178,115 | 890,574 | 289,796.9 | 1,448,984 |

5.2.4. Дээд боловсрол

• Дээд боловсролын салбарын урсгал зардлыг оны үнээр жил тутам 10 хувиар нэмэгдүүлэхээр тооцов.

Хүснэгт 29. Дээд боловсролын зардлын бүтэц

(төгрөгөөр)

| | 2006-2010 дундаж | 2006-2010 нийт | 2011-2015 дундаж | 2011-2015 нийт |
|---|---|---|---|---|
| 1. Урсгал зардал | 0 | 0 | 0 | 0 |
| 1.1. Цалин, хөлс | 0 | 0 | 0 | 0 |
| 1.3. Нийгмийн даатгал | 0 | 0 | 0 | 0 |
| 1.5. Бусад урсгал зардал | 30,701,017 | 153,505,084 | 49,444,294 | 247,221,472 |
| 1. Нийт урсгал зардал | 30,701,017 | 153,505,084 | 49,444,294 | 247,221,472 |
| Нийт зардал | 30,701,017 | 153,505,084 | 49,444,294 | 247,221,472 |

• Их, дээд сургуульд суралцагчдад олгох сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн хэмжээг оны үнээр жилд дунджаар 15 хувь нэмэгдүүлнэ.

• Их, дээд сургуульд суралцагчдад олгох сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтэд зориулж 2006-2015 онуудад жилд дунджаар 310.1 тэрбум төгрөг, үүнээс 233.0 тэрбум төгрөгийг инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, ХАА, анагаах ухааны мэргэжлийн чиглэлээр суралцах оюутнуудад олгохоор төлөвлөсөн.

• Их, дээд сургуулийн багш нарын мэргэжлийг дотооодод дээшлүүлэхэд 2006-2015 онуудад 499.3 сая төгрөг, гадаадад мэргэжил дээшлүүлэхэд 5.6 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдана. Дээд боловсролын багш нарын дотоодод мэргэжил дээшлүүлэх зардлыг жилд 8 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон.

• Дээд боловсролын хөрөнгө оруулалтын зардлыг жилд 8 хувиар нэмэгдүүлэхэд 2006-2010 онуудад жилд дунджаар 633.6 сая төгрөг, 2011-2015 онуудад жилд дунджаар 930.9 сая төгрөгийн санхүүжилт шаардагдаж байна.

Хүснэгт 30. Дээд боловсролд төвлөрсөн хөрөнгө оруулалтаас олгох зардал

(төгрөгөөр)

| | 2006-2010 жилийн дундаж | 2006-2010 нийт | 2011-2015 жилийн дундаж | 2011-2015 нийт |
|---|---|---|---|---|
| Тоног төхөөрөмж | 633,592.9 | 3,167,965 | 930,956 | 4,654,779 |
| Дотоодод багшийн мэргэжлийг дээшлүүлэх | 38,015.5 | 190,078 | 55,857 | 279,287 |
| Гадаадад багшийн мэргэжлийг дээшлүүлэх | 422,543.1 | 2,112,716 | 620,854 | 3,104,272 |
| Буцалтгүй тусламж ба зээл | 2,059,765,1.0 | 102,988,255 | 41,429,234 | 207,146,168 |

5.2.5. Насанд хүрэгчдийн албан бус боловсрол

• Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв, сум, дүүргийн Гэгээрэл, хөгжил, албан бус боловсролын төвийн санхүүжилтэд 2006-2015 онуудад 5.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоно.

• Албан бус боловсролын багш нарын мэргэжлийг дээшлүүлэх зардлыг ЕБС-ийн багш нарын мэргэжил дээшлүүлэх нэгдсэн зардалд тусган тооцсон.

Хүснэгт 31. АББ-д төвлөрсөн хөрөнгө оруулалтаас олгох зардал

| | 2005 | 2006-2010 жилийн дундаж | 2006-2010 нийт | 2011-2015 жилийн дундаж | 2011-2015 нийт |
|---|---|---|---|---|---|
| АББ-ын зайны сургалтын төв | 27,000.0 | 34,214.0 | 171,070.1 | 50,271.6 | 251,358.1 |
| Гэгээрлийн төвүүд | 454,280.4 | 400,324.7 | 2,001,623.4 | 646,002.0 | 3,230,010.0 |

5.3. Улсын төсөв ба боловсролын зардал, дутагдах нөөцийн тооцоо

Боловсролын хөгжлийн мастер төлөвлөгөөний санхүүгийн тооцоог хийхдээ нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн өсөлтийг 10.4 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүнд улсын төсвийн эзлэх хувийг 47.0 хувь, боловсролын нийт зардлыг улсын нийт төсвийн зарлагын 20 хувиас багагүй байхаар төсөөлж хийсэн.

Хүснэгт 32. Улсын төсөв ба боловсролын зардал

| | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг хүнд ногдох ДНБ ('000 төг) | 736.5 | 813.1 | 897.7 | 991.1 | 1094.2 | 1208 | 1333.6 | 1472.3 | 1625.4 | 1794.4 |
| ДНБ ('000000 төг) | 1,876,774 | 2,088,735 | 2,324,897 | 2,588,556 | 2,886,530 | 3,224,228 | 3,609,107 | 4,039,697 | 4,526,165 | 5,077,109 |
| Улсын төсвийн ДНБ-д эзлэх хувь | 47.1% | 47.1% | 47.1% | 47.1% | 47.1% | 47.1% | 47.1% | 47.1% | 47.1% | 47% |
| Төгрөгөөр ('000000) | 883,900 | 983,794 | 1,095,026 | 1,219,210 | 1,359,556 | 1,518,611 | 1,699,889 | 1,902,697 | 2,131,824 | 2,391,319 |
| Улсын нийт төсөвт боловсролын эзлэх хувь | 19.0% | 19.8% | 20.0% | 20.0% | 20.0% | 20.0% | 20.0% | 20.0% | 20.0% | 20% |

Дээр дурдсан хандлагад тулгуурлан хийсэн санхүүгийн тооцоогоор боловсролын зардалд 2006-2010 оны хооронд жилд дунджаар 252,3 тэрбум төг, 2011-2015 оны хооронд жилд дунджаар 425,0 тэрбум төгрөг шаардагдах тооцоо гарч байна.

Хүснэгт 33. Боловсролын нийт зардал (2006-2015)

| | 2006 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|
| Боловсролын нийт зардал | 210,330,686 | 242,830,258 | 297,728,974 | 530,871,138 |
| Жилийн өсөлт (өмнөх онтой харьцуулснаар) | 31.5% | 4.7% | 11.5% | 12.9% |
| Албан боловсролын нийт зардал (төгрөгөөр) | 158,237,562 | 193,937,691 | 236,878,082 | 415,766,184 |
| Үүнээс: Бага насны хүүхдийн боловсрол | 33,094,216 | 40,025,706 | 48,440,616 | 87,034,283 |
| Үүнээс: Ерөнхий боловсрол (бага, дунд, ахлах) | 91,896,096 | 113,783,335 | 138,665,338 | 235,883,829 |
| Үүнээс: Мэргэжлийн боловсрол сургалт | 8,103,503 | 9,704,717 | 12,959,170 | 33,560,434 |
| Үүнээс: Дээд боловсрол | 25,143,746 | 30,423,933 | 36,812,959 | 59,287,638 |
| Бусад зардал (төгрөгөөр) | 52,093,124 | 48,892,567 | 60,850,892 | 115,104,954 |
| Нийт зардалд эзлэх хувиар | | | | |
| Албан боловсролын эзлэх хувь | 75.2% | 79.9% | 79.6% | 78.3% |
| Үүнээс: Бага насны хүүхдийн боловсрол | 15.7% | 16.5% | 16.3% | 16.4% |
| Үүнээс: Ерөнхий боловсрол (бага, дунд, ахлах) | 43.7% | 46.9% | 46.6% | 44.4% |
| Үүнээс: Мэргэжлийн боловсрол сургалт | 3.9% | 4.0% | 4.4% | 6.3% |
| Үүнээс: Дээд боловсрол | 12.0% | 12.5% | 12.4% | 11.2% |
| АББ-ын болон бусад зардлын эзлэх хувь | 24.8% | 20.1% | 20.4% | 21.7% |
| Нийт дүн | 100.0% | 100.0% | 100.0% | 100.0% |

Мастер төлөвлөгөөний боловсролын зардлын талаарх тооцоо нь Монгол Улсын төсөвт төдийлөн хүндрэл учруулахааргүй байгаа болно. Монгол Улсын төрөөс боловсролын санхүүжилтийн талаар баримталж байгаа бодлого болон 2000-2004 оны эдийн засгийн өсөлт цаашид ч хэвээр хадгалагдах тохиолдолд 2006-2010 оны хугацаанд боловсролд шаардагдах нийт зардлын 86.5 хувийг, 2011-2015 оны хугацаанд 90.7 хувийг улсын төсвөөс хариуцах боломжтой болно.

Хүснэгт 34. Боловсролын нийт зардалд улсын төсвийн эзлэх хувь (2006-2015)

| Он | Боловсролын нийт зардал ('000000 төгрөгөөр) | Улсын төсвөөс гаргах зардал ('000000 төгрөгөөр) | Боловсролын нийт зардалд улсын төсвийн эзлэх хувь |
|---|---|---|---|
| 2006 | 210,330.7 | 167,882 | 79.8% |
| 2007 | 232,014.3 | 194,545 | 83.9% |

| | | | |
|---|---|---|---|
| 2008 | 242,830.3 | 219,005 | 90.2% |
| 2009 | 267,033.9 | 243,842 | 91.3% |
| 2010 | 297,729.0 | 271,911 | 91.3% |
| 2011 | 332,788.5 | 303,722 | 91.3% |
| 2012 | 371,807.8 | 339,978 | 91.4% |
| 2013 | 417,606.3 | 380,539 | 91.1% |
| 2014 | 470,130.7 | 426,365 | 90.7% |
| 2015 | 530,871.1 | 478,264 | 90.1% |

2004 онд боловсролын нийт зардлын гүйцэтгэлийн 87.1 хувийг (136.6 тэрбум төгрөг) улсын төсвөөс, үлдсэн 12.9 хувь болох 20.2 тэрбум төгрөгийг хандивлагчдаас санхүүжүүлсэн бол 2005 онд боловсролын нийт зардлын гүйцэтгэлийн 83.1 хувийг улсын төсвөөс, үлдсэн 16.9 хувь болох 31.7 тэрбум төгрөгийг хандивлагчдаас санхүүжүүлсэн.

Хүснэгт 35. Боловсролын дутагдах нийт зардал (2006-2015)

| Он | Боловсролын нийт дутагдах зардал ('000000төг) | Боловсролын нийт дутагдах зардал (сая ам.доллар) | Боловсролын нийт дутагдах зардал (хувиар) |
|---|---|---|---|
| 2006 | 42,448.3 | 34.8 | 20.2% |
| 2007 | 37,469.0 | 30.7 | 16.1% |
| 2008 | 23,825.0 | 19.5 | 9.8% |
| 2009 | 23,191.9 | 19.0 | 8.7% |
| 2010 | 25,817.8 | 21.2 | 8.7% |
| 2011 | 29,066.2 | 23.8 | 8.7% |
| 2012 | 31,829.9 | 26.1 | 8.6% |
| 2013 | 37,066.9 | 30.4 | 8.9% |
| 2014 | 43,766.0 | 35.9 | 9.3% |
| 2015 | 52,607.4 | 43.1 | 9.9% |

Боловсролын зардлын хэрэгцээ ба улсын төсвийн боломжийг харьцуулан үзэхэд 2006-2010 оны хооронд жилд дунджаар 32.8 тэрбум төгрөг, 2011-2015 оны хооронд жилд дунджаар 39.2 тэрбум төгрөгийн эх үүсвэр дутагдана[1].

## ҮI БҮЛЭГ
## МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УДИРДЛАГА, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

6.1. Төлөвлөгөөний удирдлага, байгууллагуудын үүрэг хариуцлага

Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг Монгол Улсын

[1] 2006 оны байдлаар хандивлагчдаас 2006 онд 32.9 тэрбум төгрөг, 2007 онд 20.2 тэрбум төгрөг, 2008 онд 4.2 тэрбум төгрөг, 2009 онд 3.3 тэрбум төгрөгийн зээл, тусламж орж ирэх боломжтой болсон байна.

нийгэм, эдийн засаг, хүний хөгжлийн талаархи хөгжлийн суурь бодлоготой уялдуулан төр, засаг захиргааны болон боловсролын тогтолцооны бүтцэд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Салбар дамнасан төлөвлөлт, удирдлагын хандлага нь Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлагын үндсэн арга зам болно.

Засгийн газрын үүрэг, хариуцлага, манлайлалд тулгуурлан Засгийн газар, хандивлагчид, олон улсын байгууллагуудын нэгдсэн байр суурь, бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдал, уялдаа холбоог бий болгох, мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүх талын бодит оролцоог бий болгох, үр дүнд суурилсан төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, үйл ажиллагааг бий болгох, мэдээллийн нээлттэй тогтолцоог бүрдүүлэх үндсэн дээр мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар дамнасан төлөвлөлт, удирдлагыг бий болгоно.

Засгийн газрын үүрэг хариуцлага, манлайлал нь мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлагын суурь нөхцөл болно.

Монгол Улсын Засгийн газраас мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дор дурдсан чиг үүрэг, хариуцлагыг хүлээнэ:

• төлөвлөгөөгөөр дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах бодлого, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх;

• мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дутагдах санхүүжилтийг Монгол Улсын хөгжлийн албан ёсны зээл, тусламжийг зохицуулах үндэсний бодлогын хүрээнд гадаад эх үүсвэрээр бүрдүүлэхэд анхаарах;

• төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар салбарын яамдын уялдаа холбоог хангах, үндэсний болон орон нутгийн түвшинд нэгдмэл удирдлагыг бий болгох;

• төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хандивлагчид, олон улсын байгууллагууд, бүх талын оролцоог хангах, тэдгээрийн үйл ажиллагааг удирдах, уялдуулан зохицуулах;

• үндэсний болон орон нутгийн түвшинд боловсролын удирдлага, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний чадавхийг бэхжүүлэх.

Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Засгийн газраас хүлээх үүрэг, хариуцлагыг салбарын бусад яамдтай хамтран гардан хэрэгжүүлнэ. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор БСШУ-ны сайдаар удирдуулсан төлөвлөгөөний удирдлага, хэрэгжилтийг зохицуулах бодлогын зөвлөлийг байгуулна. Энэхүү бодлогын зөвлөл нь холбогдох яамдын дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, боловсролын хандивлагчдын зөвлөлдөх бүтцийг тэргүүлэх байгууллагуудын төлөөллөөс бүрдэнэ.

Энэхүү бодлогын зөвлөл нь төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой салбар дундын зохицуулалтыг хийх, санхүүгийн төлөвлөлт, дутагдах санхүүжилтийг хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд олон талт, гадаад эх үүсвэрээс бүрдүүлэх, мастер төлөвлөгөөний жил бүрийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх, Засгийн газрын түвшинд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг хэлэлцэх, шийдвэрлүүлэх чиг үүргийг хүлээнэ.

Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, үе шат бүрийн төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг хариуцсан байнгын үйл ажиллагааг БСШУЯ хариуцна.

Боловсролын хандивлагчдын зөвлөлдөх бүтэц нь мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Засгийн газар, хандивлагчид, олон улсын байгууллагуудын хамтын үүрэг, хариуцлагыг бий болгох, үйл ажиллагааны нэгдмэл байдал, уялдаа холбоог хангах, мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд олон талт нөөцийн эх үүсвэрүүдийг бий болгох, зээл, тусламжийг оновчтой, үр дүнтэйгээр ашиглах, түүний үр ашгийг нэмэгдүүлэх талаар БСШУЯ,

хандивлагчид, олон улсын байгууллагуудын зөвлөлдөх үндсэн баг болно.

Боловсролын хандивлагчдын зөвлөлдөх бүтэц нь хоёр талт болон олон талт олон улсын хөгжлийн байгууллагууд, БСШУЯ-ны гишүүнчлэлээс бүрдэнэ. Боловсролын хандивлагчдын зөвлөлдөх бүтцийн үйл ажиллагааг тэргүүлэн удирдах хандивлагч байгууллагуудыг гишүүн байгууллагуудын саналын үндсэн дээр сонгоно. БСШУЯ нь боловсролын хандивлагчдын зөвлөлдөх бүтцийн үйл ажиллагааг хамтран удирдах байгууллага болно.

Энэхүү зөвлөлдөх механизм нь:

- мастер төлөвлөгөөний нэгдмэл зорилтын дор Засгийн газар, хандивлагчдын хамтарсан үйл ажиллагааны нэгдмэл төлөвлөгөө боловсруулах;

- мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар Засгийн газар, хандивлагч тус бүрийн хариуцах үйл ажиллагааны хамрах хүрээ, чиглэл, санхүүжилтийн нэгдсэн хүрээг тодорхойлох;

- хандивлагчдын зээл, тусламжаар олгогдох бараа, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг хийх, түүний ашиглалтын үр ашиг, үр нөлөөг сайжруулах, санхүүжилтийг хийх, санхүүгийн нэгдсэн тайлан, баланс гаргах боломж бүхий үр дүнтэй, шуурхай, уян хатан тогтолцоог бий болгох;

- БСШУЯ-наас хандивлагчдад тавих төсөл, хөтөлбөрүүдийг хэлэлцэх үндсэн дээр хэрэгжиж байгаа болон шинээр хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийн уялдаа, холбоог хангах, мастер төлөвлөгөөний дутагдах санхүүжилтийг бий болгох;

- Засгийн газар болон хандивлагчдын хооронд, хандивлагчдыг өөр хооронд нь үйл ажиллагааны уялдаа холбоогоо хангах, давхардлыг арилгах мэдээлэл солилцох орчин бий болгох;

- хандивлагчдын үйл ажиллагааны талаар удирдлага, мэдээллийн нэгдсэн бааз, сүлжээ байгуулах;

- хандивлагчдын тусламж, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг үнэлэх хяналт-шинжилгээний нэгдсэн үзүүлэлт боловсруулах, бодлогын дүн шинжилгээ хийх нэгдсэн зохицуулалтыг бий болгох;

- Засгийн газар, хандивлагчдын хамтын үйл ажиллагааны үр дүнг нэгдмэл байдлаар хэлэлцэх, санал солилцох, цаашдын хамтын үйл ажиллагааг тодорхойлох жил бүрийн тайлант үнэлгээг хамтран хэлэлцэх;

- Засгийн газар, хандивлагчдын хоорондын хамтын үйл ажиллагааг салбар дамнасан, үр дүнд суурилсан удирдлага, төлөвлөлтийн хандлагад тулгуурлан нэгдмэл байдлаар зохион байгуулах байнгын, институтчилэгдсэн үйл ажиллагааг бий болгох, энэ талаар БСШУЯ-ны хүний нөөцийн болон үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ.

Хандивлагчдын зөвлөлдөх бүтэц нь тогтвортой үйл ажиллагаатай байх бөгөөд үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлдөх уулзалт болно. БСШУЯ болон хандивлагчдын зөвлөлдөх механизмын гишүүн байгууллага бүрийн цахим шуудангийн хаягийг нэгтгэсэн нэгдсэн цахим шуудангийн хаягаар мэдээлэл солилцох үндсэн дээр хоёр талын болон олон талын мэдээллийг бүх талууд зэрэг хүлээн авах боломжийг бий болгоно. Боловсролын хандивлагчдын зөвлөлдөх механизмын нэгдсэн цахим шуудангийн хаягт хамтран ажилладаг бүх хандивлагчдын бүсийн төв болон удирдах төв байгууллагуудын хаягийг нэгтгэж улс дамнасан мэдээллийн нээлттэй байдлыг бий болгоно. БСШУЯ, хандивлагчдын хооронд мэдээлэл, холбооны технологид суурилсан харилцаа холбоог бий болгосноор бүх талуудын хооронд байнга мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа уялдуулах бодит боломжийг бүрдүүлнэ.

Хандивлагчдын зөвлөлдөх бүтцээс гаргасан зөвлөмжийг БСШУ-ны сайдын шийдвэрээр, шаардлагатай асуудлуудыг Засгийн газрын шийдвэрээр баталгаажуулан хэрэгжүүлнэ.

Хандивлагчдын зөвлөлдөх бүтцийн уулзалтын бэлтгэл ажлыг хангах, нарийн бичгийн даргын газрын чиг үүргийг БСШУЯ-ны Гадаад, хамтын ажиллагааны хэлтэс хариуцан гүйцэтгэнэ.

Монголын боловсролын салбарын болон аймаг, нийслэлийн боловсролын талаархи жил бүрийн төлөвлөгөөнүүдээр дамжуулан мастер төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

Мастер төлөвлөгөөнд дэвшүүлсэн салбарын түвшинд шийдвэрлэх зорилт, үйл ажиллагааг боловсролын салбарын жил бүрийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ. Боловсролын салбарын жил бүрийн төлөвлөгөөг БСШУЯ баталж, хариуцан хэрэгжүүлнэ.

БСШУЯ-наас мастер төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтын хүрээнд аймаг, нийслэл тус бүрийн түвшинд жил, жилд тавигдах ялгаатай зорилт, үйл ажиллагааг тодорхойлно. БСШУ-ны сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай боловсролын талаар байгуулах жил бүрийн бүтээгдэхүүн нийлүүлэх, үр дүнгийн гэрээг БСШУЯ-наас мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар боловсруулсан орон нутаг тус бүрийн төлөвлөлтийг үндэслэн байгуулж, хэрэгжилтийг үнэлнэ.

БСШУЯ-наас мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар боловсролын мэргэжлийн болон эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагуудын үүрэг оролцоог тодорхойлж, тэдний жил бүр хийх үйл ажиллагааны зорилтыг төлөвлөнө. БСШУ-ны сайдаас боловсролын мэргэжлийн болон сургалтын байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах жил бүрийн бүтээгдэхүүн нийлүүлэх, үр дүнгийн гэрээнд БСШУЯ-наас төлөвлөсөн тухайн байгууллагын гүйцэтгэх үүрэг, хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тусгасан байна.

6.2. Хяналт-шинжилгээ

Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг үнэлэх хяналт-шинжилгээний үзүүлэлтүүдийг боловсруулах, боловсролын удирдлага, мэдээллийн системд тулгуурлан мэдээллийг цуглуулах, мэдээллийн бааз байгуулах, бодлогын дүн шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтийн талаархи тайлан, үнэлгээг Засгийн газар болон хандивлагчид, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг БСШУЯ хариуцан гүйцэтгэнэ.

БСШУЯ-наас мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шат бүрт хийгдэх хяналт-шинжилгээний төрлийг тогтоож, хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох талуудтай хамтран бодлого, төлөвлөлттэйгээр хэрэгжүүлнэ.

Мастер төлөвлөгөөний хяналт-шинжилгээний салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг нь хандивлагчдын тусламж, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх хяналт-шинжилгээний ажил болно. БСШУЯ, хандивлагчидтай хамтран боловсруулсан хандивлагчдын тусламж, төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг үнэлэх хяналт-шинжилгээний нэгдсэн үзүүлэлтүүдийг боловсруулж, нэгдсэн зохицуулалтайгаар бодлогын дүн шинжилгээ, үнэлгээг үе шаттай зохион байгуулна.

БСШУЯ мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгийн талаархи хяналт-шинжилгээний тайланг жил бүрийн 9 дүгээр сард Засгийн газарт танилцуулж, цаашдын үйл ажиллагааг төлөвлөнө.

Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх салбар дамнасан нэгдсэн үнэлгээг хоёр жил тутамд хийх бөгөөд энэхүү үнэлгээг БСШУЯ тэргүүлж холбогдох яамд, хандивлагчид, олон нийтийн оролцоотойгоор гүйцэтгэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 320487

Хэвлэлийн хуудас 4